


ДЭЭРЭЭС ИНДАУМЕНТ ХҮРТЭГЧ

АРИУН СҮМИЙН БЭЛТГЭЛИЙН СЕМИНАР



БАГШИЙН ГАРЫН АВЛАГА

ДЭЭРЭЭС ИНДАУМЕНТ ХҮРТЭГЧ

АРИУН СҮМИЙН БЭЛТГЭЛИЙН СЕМИНАР


БАГШИЙН ГАРЫН АВЛАГА

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээтнүүдийн Сүмээс
хэвлэн гаргав.
Солт Лэйк Сити, Юта

© 1995, 2003 Intellectual Reserve, Inc.
Бүх эрхийг эдэлнэ.
Хоёр дахь хэвлэл 2003
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.


Англи эхийн зөвшөөрөл: 3/03
Орчуулгын зөвшөөрөл: 3/03

Endowed From On High: Temple Preparation Seminar-ын орчуулга
Mongolian



АГУУЛГА

Оршил	iv
1. Ариун Сүм Авралын Агуу Их Төлөвлөгөөний Тухай Заадаг	1
2. Бид Ариун Сүмд Орохын Тулд Зохистой Байх Ёстой	7
3. Ариун Сүмийн Ажил Бидний Амьдралд Агуу Их Адислалуудыг Авчирдаг	14
4. Ариун Сүмийн Ёслолууд Хийгээд Гэрээнүүдийг Хүлээн Авах нь	18
5. Бэлэг Тэмдгүүдээр Дамжуулан Их Эзэнээс Суралцах нь	23
6. Ариун Сүмд Орохоор Бэлтгэх нь	29
7. Ариун Сүмд Орсноор Ирэх Адислалуудыг Үргэлжлүүлэн Хүртэх нь	34



ОРШИЛ

ЗОРИЛГО

Энэхүү заавар хичээл нь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүдийг ариун сүмийн зөвшөөрлийн бичиг авч, ариун сүмд орохоор бэлтгэхэд нь туслах зорилготой юм. Ариун сүмд өмнө нь орсон гишүүд мөн ариун сүмийн тухай илүү ихийг мэдэж авахын тулд энэ хичээлд оролцож болно.

ОРОЛЦОГЧИД

Энэ хичээлд оролцогчид нь ариун сүмд орохыг хүсэлтэй байх учиртай бөгөөд ариун сүмийн зөвшөөрлийн бичиг авахуйц зохистой байх ёстой. Хэрэв тэд зөвшөөрлийн бичиг хараахан аваагүй байгаа бол уг зөвшөөрлийн бичгийг авахад бэлтгэх ёстой.

Хэрэв оролцогчид нь *Сайн Мэдээний Зарчмууд* гарын авлагаас суралцдаг Ням Гарагийн хичээлд хараахан оролцоогүй байгаа бол, тэднийг энэ хичээлд оролцохоосоо өмнө үүнд суухыг шаардахгүй боловч, суухыг зөвлөдөг. Энэ хичээлд суухын өмнө тэд сайн мэдээний сургаал болон зарчмууд, түүнчлэн ариун явдлын хууль, Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахих, Мэргэн Ухааны Үг, аравны нэгийн хууль зэрэг Бурханы зарлигуудыг дуулгавартай дагах талаар үндэслэл бүхий ойлголттой болсон байх ёстой. Зохистой байдал болон хувь хүний зөв шударга байдлынхаа төлөө хичээл зүтгэл гаргах нь ариун сүмийн ёслолуудад оролцоход зайлшгүй шаардлагатай байдаг.

Бишоп буюу салбарын ерөнхийлөгчийн удирдлаган дор хэсэг буюу салбарын зөвлөл гэр бүлүүдийг батжуулж, эрэгтэйчүүдийг Мелкизедек Санваар хүртэхэд туслахаар чармайхдаа уг хичээлийг ашиглах арга замуудыг ярилцаж болно.

Оролцогч нэг бүрийг уг хичээлд суухыг бишоп буюу салбарын ерөнхийлөгч эсвэл хэсэг буюу салбар дахь Мелкизэдэк Санваарын өөр нэг удирдагч биечлэн урих ёстой.

ЦАГ ХУГАЦАА БА ГАЗАР

Энэ хичээлийн ангиуд нь хэмжээгээрээ янз бүр байх боловч ихэнхдээ хэсэг буюу салбарын түвшинд жижиг бүлгүүдэд заагдах ёстой. Хичээлийг цуглааны байранд буюу гэрт зааж болно. Хичээл заах цаг, газар мөн хэдэн удаа хийх нь оролцогчид болон багшийн хувьд тохиромжтой байх ёстой.

Хичээлийн материал нь долоон хэсэгт хуваагддаг. Гэвч ангийн гишүүдэд хичээл болгонд ямар хугацаа шаардлагатай байна, багш тэр хугацааг зарцуулах ёстой. Энэ нь хичээл болгонд нэгээс илүү цаг шаардагдаж болно гэсэн үг юм.

ХИЧЭЭЛИЙН МАТЕРИАЛУУД

Хичээл дээр ангийн гишүүн бүрд судрууд хүрэлцээтэй байх ёстой. Мөн түүнчлэн суралцагчдад зориулсан энэ хичээлийн нэмэлт материал *Ариун Сүмд Ороход Бэлтгэх нь* (36793) товхимол хүн бүрт хүрэлцээтэй байх хэрэгтэй. Хичээлүүдийн турш энэ товхимлоос байнга иш татаж байх шаардлагатай бөгөөд уг хичээл заагдаж байгаа долоо хоногийн турш үүнийг уншиж судлахыг гишүүдээс хүсэх хэрэгтэй.

БАГШ НАР

Хувь хүмүүс буюу гэрлэсэн хосуудаар энэ хичээлийг заалгахаар дуудаж болно. Багш нар сайн мэдээний талаар хүчтэй гэрчлэлтэй мөн Сүнсний өдөөлтүүдэд мэдрэмтгий байх ёстой. Тэд индаумент хүртсэн, ариун сүмийн хүчин төгөлдөр зөвшөөрлийн бичигтэй, ариун сүмд болдог зүйлүүдийн ач холбогдол хийгээд ариун нандин чанарыг ойлгодог гишүүд байх ёстой.

Багш нар боломжтой үедээ оролцогчдыг ариун сүмийн ёслолуудаа авахаар ариун сүм рүү очиход нь дагалдан явах хэрэгтэй.

БАГШИД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖҮҮД

Сүмийн гишүүд ариун сүмд орохоосоо өмнө оюун санаагаараа бэлэн болсон байх ёстой. Энэхүү бэлтгэлийн нэг хэсэг болгож тэд авралын төлөвлөгөө болон ариун сүмийн ажилтай холбоотой сургаалуудыг хангалттай сайн ойлгосон байх ёстой. Бусдын амьдралд тохиолдох хамгийн ариун нандин үйл явдлуудын нэг тийш хөтлөх энэ бэлтгэлийг хангахад тэдэнд туслах сайхан завшаан танд бий билээ. Сүнсний өдөөлтөд мэдрэмтгий байгун, тэгснээр та оролцогчдод хамгийн дөхөмтэй сайн аргаар хичээлийн материалыг зааж чадна. “Итгэлийн залбирлаар Сүнс та нарт өгөгдөх болно; мөн хэрэв та нар Сүнсийг эс хүлээн авбаас та нар зааж эс чадна” (С ба Г 42:14) гэсэн Их Эзэний зөвлөгөөг санагтун.

Хичээлийн материалууд хоорондоо хэрхэн уялдаатайг ойлгохын тулд анхны хичээлийн өмнө энэ гарын авлагыг эхнээс нь дуустал унш. Санаануудыг ойлгож, тэдгээрийг сайн заахын тулд хичээл болгоныг урьдчилан сайн бэлтгэ. Та хичээл зааж байх үедээ хичээлийг цааш нь үргэлжлүүлэхийн өмнө санаануудыг оролцогчид бүрэн ойлгосон гэдэгт бат итгэлтэй байх ёстой. Хичээлүүдийг яаруу заах хэрэггүй. Хүлээцтэй байж, өгүүлж буй зүйлийн талаар тунгаан бодож, түүнд хариулт өгөх боломжийг оролцогчдод олго.

Хичээл бүрийн өмнө түүнчлэн хичээлийн явцад асуулт тавьж, санаануудыг хамтран хэлэлцэх боломжийг ангийн гишүүдэд олго. Энд мэдэж авсан зарчмуудыг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тэдэнд тусал. Асуултуудад судрууд, хожмын үеийн бошиглогчдын сургаалууд болон Их Эзэний Сүнсний удирдамжийг ашиглан хариул.

Энэ хичээлийн туршид ариун сүмийн ёслолуудын ариун нандин мөн чанарыг санагтун. Дараах нотолгоонуудад тайлбарласанчлан, ариун сүмийн ажлын зарим зүйлүүдийг ариун сүмээс гадуур ярилцдаггүй ёстой билээ.

“Бид ариун сүмийн ёслолуудыг ариун сүмээс гадуур ярилцдаггүй. Ариун сүмийн эдгээр ёслолуудын тухай мэдлэг нь бусад хүмүүст эдгээр мэдлэгүүдийг хэзээ ч мэдүүлэхгүй байх үүрэг хүлээсэн байх учиртай цөөн хэдхэн сонгомол хүнээр хэзээ ч хязгаарлагдаж байсангүй. Үнэн хэрэгтээ үүний эсрэг юм. Ариун сүмийн шаардлагад тэнцсэн байх хийгээд үүнд бэлтгэхийн төлөө бид их хүч чармайлтаар хүн болгоноос шаргуугаар хүсдэг билээ. . . .

“Ариун сүмийн ёслолууд болон ёс жаягууд нь энгийн юм. Эдгээр нь сайхан. Эдгээр нь ариун нандин. Эдгээрийг бэлтгэгдээгүй хүмүүст өгөхгүйн тулд нууцалдаг билээ” (*Ариун Сүмд Ороход Бэлтгэх нь, 2*).

Ариун сүмийн тухай гэрчлэлээ бэхжүүлэхийн төлөө ажилла, түүнчлэн зааж байгаа зарчмуудынхаа үнэний талаар ангидаа байн байн гэрчилж бай. Мөн түүнчлэн зохих байдлаар гэрчлэлээ илэрхийлэх боломжийг ангийн гишүүдэд олго.

Ариун сүмийн ажлын амин чухал ач холбогдлыг байнга санаж бай. Ахлагч Бойд К.Пакер хэлэхдээ: “Ёслолууд хийгээд гэрээнүүд нь бидний хувьд Түүний дэргэд очих итгэмжлэх жуух юм. Тэдгээрийг зохистойгоор хүлээж авах нь бүх насаараа зочин нь боллоо гэсэн үг; энэ цагаас хойш тэдгээрийг сахих нь зуурдын байдлын уриа юм” гэжээ (in Conference Report, Apr. 1987, 27; or *Ensign*, May 1987, 24).



АРИУН СҮМ АВРАЛЫН АГУУ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙ ЗААДАГ

“Цорын ганц үнэн
Бурхан Таныг
болон Таны
илгээсэн Есүс
Христийг мэдэх нь
мөнхийн амь мөн”
(Иохан 17:3).

ЗОРИЛГО

Ариун сүмүүдэд авралын төлөвлөгөө заагддаг гэдгийг ойлгоход ангийн гишүүдэд тусална.

БЭЛТГЭЛ

1. Хичээлийг эхлэхийн өмнө авралын төлөвлөгөөг харуулсан гүйцэт бус зургийг самбарт зурах буюу цаасан дээр бичиж бэлтгэсэн байх (хуудас 3-ыг үз). (Үүнтэй адил гүйцэт бус зургийг ангийн гишүүн болгонд зориулан жижиг цаасан дээр зурж бэлтгээд хичээлийн ярилцлагын үеэр гүйцээн зуруулж болно.)
2. Ангийн гишүүн бүр судартай байгаа эсэхийг анхаар. Мөн түүнчлэн *Ариун Сүмд Ороход Бэлтгэх нь* товхимолыг ангийн гишүүн бүрд өг. Эдгээрийг хичээлийн материалуудын нэг хэсэг болгон захиалсан байх ёстой.
3. Хичээлийн хоёр дахь хэсгийг бэлтгэхэд ангийн зарим гишүүдийг та өөртөө туслуулахаар томилж болно. Авралын төлөвлөгөөний хэсэг тус бүрд (зуурдын байдлын өмнөх амьдрал, Уналт г.м.) дурдсан судрын ишлэлүүдийг ангийн нэг гишүүнд өгч, эдгээр судрууд авралын төлөвлөгөөний талаар юу зааж байгааг нэгтгэн дүгнэж ярихаар хичээлд бэлтгэж ирэхийг түүнээс хүсч болно.
4. Хэрэв *1-р Шатны Видео* дүрс бичлэгийн хуурцаг (56779) байгаа бол, 13 минут гардаг “Хүмүүн Аз Жаргалын Эрэлд”-ийг та үзүүлж болно.

ХИЧЭЭЛИЙГ ЗААХ НЬ

Ариун Сүм Бол Сүнслэг Сургууль Мөн

Нээлтийн залбирал хийхийг хэн нэгнээс хүс.

Хичээл болгонд судруудыг ашиглана гэдгийг тайлбарла. Хичээл болгонд судраа авчрахыг ангийн гишүүдэд уриал.

Ариун Сүмд Ороход Бэлтгэх нь товхимолыг ангийн гишүүн бүрд тарааж өг. Уг товхимол нь энэ хичээлийн суралцагчдад зориулсан нэмэлт материал юм гэдгийг тайлбарла. Энэ товхимолын материалыг хичээл болгон дээр ярилцахаас гадна ангийн гишүүн болгон

хичээл заагдаж байгаа долоо хоногийн үеэр товхимолыг уншсан байх ёстой.

Ариун сүм бол амьдралын зорилго хийгээд авралын төлөвлөгөөний тухай илүү ихийг мэдэж авахад бидэнд тусалдаг сүнслэг сургууль юм гэдгийг тайлбарлан хичээлийг эхэл.

Ариун сүмд бидний сурдаг зүйлээс заримыг нь тайлбарласан дараах ишлэлүүдийг ангийн гишүүдээр уншуул:

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлэхдээ, ариун сүм бол “Бурханы эрхэм сайхан хийгээд ариун нандин зүйлүүдийн тухай зааварладаг сургууль байдаг. Энд бид бүх үеийнхний Түүний хөвгүүд, охидын нэрийн өмнөөс Эцэгийг хайрлах төлөвлөгөөг гаргаад байна. Энд бид энэ амьдралаар дамжин зуурдын байдлын өмнөх оршихуйгаас дараагийн амьдрал уруу хийх урт аяныг өөрсдийнхөө өмнө тоймлон гаргаад байна. Агуу тулгуур ба суурь үнэнүүд нь сонсдог бүхний ойлголтын хүрээнд тодорхой хийгээд нэн энгийн байдлаар заагддаг билээ” гэсэн (“The Salt Lake Temple,” *Ensign*, Mar. 1993, 5–6).

Индаумент гэж нэрлэгддэг ариун сүмийн ёслол нь мөнх амьдралд зайлшгүй шаардлагатай зааврыг бидэнд өгдөг тухай Ерөнхийлөгч Бригам Ян сургахдаа: “Таны индаумент энэ амьдралаас таныг хагацсаны дараа танд зайлшгүй шаардлагатай тэдгээр бүх ёслолуудыг Их Эзэний өргөөнд хүлээн авч, Эцэгийнхээ дэргэд буцаж очих боломжийг танд олгох болно” гэжээ (*Discourses of Brigham Young*, sel. John A. Widtsoe [1954], 416).

Иохан 17:3-ыг ангийн гишүүдээр уншуул.

- Энэ судар бидний олж авч болох хамгийн чухал ямар мэдлэгийн тухай заадаг вэ?

“Хэрэв тэд Их Эзэн өөрсдийн Бурханы зарлигласан бүх зүйлийг юу ч гэлээ хийх аваас бид тэднийг үүгээр нь нотлох авай” (Абрахам 3:25).

Ариун сүмд бид Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийн тухай илүү ихийг мэдэж авдаг бөгөөд ингэснээрээ бид Тэдэнтэй илүү ойртох боломжтой байдаг. Гэтэлгэлийн төлөвлөгөө буюу авралын төлөвлөгөө гэхчлэн судруудад өөр өөр нэрээр дурдагддаг бидэнд зориулсан Тэдний төлөвлөгөөний талаар бид мэдэж авдаг.

- Авралын төлөвлөгөөний талаар өдийг хүртэл амьдралдаа мэдэж авахад чинь та нарт юу тусалсан бэ?
- Авралын төлөвлөгөөний талаарх ойлголт амьдралыг тань хэрхэн адисласан бэ?


Ариун Сүмд Бид Авралын Төлөвлөгөөний Талаар Заалгадаг

Авралын төлөвлөгөө нь ариун сүмийн индаументийн нэг хэсэг хэмээн заадгийг тайлбарла. Хичээлийн энэ хэсэг нь ариун

сүмийн эдгээр сургаалуудыг ойлгоход бэлтгэхэд нь ангийн гишүүдэд туслах болно.

Самбар дахь гүйцэт бус зураг уруу анхааралаа хандуулж, уг санааг ойлгоход нь ангийн гишүүдэд туслахын тулд судрууд ашиглан дараах мэдээллийг нэгтгэн дүгнэ. Судруудын талаар ярилцаж байх үед тэдгээрийг хүснэгтийн зохих мөрөнд бич (5-р хуудсанд дахь гүйцээн зурсан хүснэгтийг үз). Хэрэв ангийн гишүүдэд өөрсдийнх нь хүснэгт байгаа бол судрын ишлэлүүдийг хүснэгтэн дээр нь нэмж бичүүл.

Хэрэв та ангийн гишүүдийг өөртөө туслуулахаар томилсон бол авралын төлөвлөгөөний тухай өөрсдийн бэлтгэсэн мэдээллийг танилцуулахыг тэднээс хүс. Энэхүү ярилцлага нь: Бид хаанаас ирсэн бэ? Бид яагаад энд дэлхий дээр байгаа вэ? Энэ амьдралын дараа бид хаашаа явах вэ? гэсэн асуултуудад төвлөрнө гэдгийг тайлбарла.



Зуурдын Байдлын Өмнөх Амьдрал

1. Бид бол Тэнгэрлэг Эцэг Бурханы сүнсэн хүүхдүүд бөгөөд газар дэлхийд ирэхээсээ өмнө Түүнтэй хамт амьдарч байсан (Ром 8:16–17-г үз).
2. Тэнгэрлэг Эцэг тэнгэрт агуу их зөвлөлийг зарлан хуралдуулсан (Абрахам 3:22–23-ыг үз). Тэрээр авралын төлөвлөгөө хэмээн нэрлэгдэх бидний мөнхийн хөгжил, аз жаргалд зориулсан төлөвлөгөөг танилцуулсан. Бид Түүний төлөвлөгөөг дагах сонголтыг хийсэн билээ.
3. Энэхүү төлөвлөгөөнд нийцүүлэн Тэнгэрлэг Эцэгийн Ууган Хүү Есүс Христ сайн дураараа бидний Аврагч болохыг хүссэн (Мосе 4:2; Абрахам 3:27-г үз).
4. Бурханы өөр нэг хүү Люсифер Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний эсрэг бослого гаргаж, “хүмүүний сонголтын эрхийг устгахыг эрэлхийлжээ.” Тэр болон түүнийг дагалдагчид тэнгэрээс хөөгдсөн бөгөөд бие махбодь хийгээд зуурдын байдлыг мэдэж

авах боломжгүй болсон юм. Люцифер хэмээн эдүгээ нэрлэгддэг Сатан зуун зууны туршид уруу таталтаар бүх хүн төрөлхтнийг өөртэйгөө адилхан өөдгүй, ёсон бус болгохоор оролдсоор байна. (Моисе 4:1, 3– 4; 2 Нифай 2:17–18- ыг үз).

Уналт

1. Адам, Ева хоёр газар дэлхийд ирэх Тэнгэрлэг Эцэгийн анхны хүүхдүүдээр сонгогдсон бөгөөд Едены Цэцэрлэгт байрлуулагджээ. Тэр үед тэдний бие махбод зуурдын байгаагүй юм (Моисе 3:7–8, 21–23-ыг үз).
2. Адам, Ева хоёр Бурханы тэдэнд идэхийг хориглосон жимсийг идэхээр сонголт хийжээ. Үүнээс болж, тэд Бурханы дэргэдээс тусгаарлагдсан байна. Энэхүү тусгаарлалтыг сүнсний үхэл гэж нэрлэдэг. Тэд зуурдын болсон бөгөөд энэ нь тэдний бие махбод зайлшгүй үхэх учиртай гэсэн үг юм. Мөн түүнчлэн тэд хүүхэдтэй болох боломжтой болов. Зуурдын байдал дахь уг шилжилтийг Уналт гэж нэрлэдэг (2 Нифай 2:19–25: С ба Г 29:40–41-ийг үз).

Зуурдын Амьдрал

1. Зуурдын байдлын өмнөх амьдралд Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг дагахаар сонгосон бүх хүмүүс энэ дэлхий дээр бие махбодыг олдог. Зуурдын амьдралынхаа үед бид итгэлээр амьдарч, мөн Тэнгэрлэг Эцэгийн оршихуйд байхгүй үедээ Түүний зарлигуудыг дуулгавартай дагахад бэлэн байна уу үгүй юү гэдгээрээ сорилтонд ордог (Алма 34:32; Абрахам 3:24–26-г үз).
2. Зуурдын байдалд хүн болгон Бурханыг дагах уу, эсвэл Сатаныг дагах уу гэдгээ сонгох эрхтэй байдаг (2 Нифай 2:27-г үз).

Үхэл ба Амилуулалт

1. Биднийг нас барахад сүнс маань сүнсний дэлхийд очиж, бие маань газар дэлхийд үлддэг. Энэхүү салалтын үе бидний амилуулалтын үе хүртэл үргэлжилдэг. Зөв шударга хүмүүсийн сүнс диваажин хэмээн нэрлэгддэг амар амгалан хийгээд аз жаргалын байдалд хүлээн авагддаг. Ёсон бус хүмүүсийн сүнс заримдаа шорон хэмээн нэрлэгддэг харанхуйн оронд очдог (Алма 40:9–14; мөн 1 Петр 3:19-ийг үз).
2. Есүс Христийн Цагаатгал болон Амилуулалт нь амилуулагдах байдлаар бие махбодийн үхлийг даван туулах замыг бүх хүн төрөлхтөнд олгодог. Амилуулалт гэдэг нь бидний сүнс болон төгс болсон бие махбодь мөнх оршихуйд дахин нэгдэх болно гэсэн үг юм (1 Коринт 15:22; 2 Нифай 9:10–13; Алма 11:42–44-ийг үз).

“Сайн мэдээний хууль, ёслолуудыг дуулгавартай дагаснаар Христийн цагаатгалаар дамжин бүх хүн төрөлхтөн аврагдах боломжтой гэдэгт бид итгэдэг” (Итгэлийн Тунхаг 1:3).

3. Есүс Христийн Цагаатгал нь мөн нүглээс цэвэршин, өршөөгдсөн байх арга замыг бидэнд хангаж өгдөг бөгөөд ингэснээр бид Бурханы дэргэд оршиж чадах юм. Аврагч бүх хүн төрөлхтний нүглүүдийн төлөө Гетсеманий Цэцэрлэг болон загалмай дээр зовж тарчилсан билээ. Түүний Цагаатгалын үр дүнд бид нүглүүдээ наманчилж, өршөөл хүртэж чаддаг. Бид сайн мэдээний дагуу амьдарснаар, мөнх амьдралын бэлгийг хүлээж авах шаардлагыг хангаж, Түүнтэй адил болдог (Мозая 3:5–12-ыг үз).

Алдар Суугийн Хаант Улсууд

Амилуулалтынүед хүн болгон алдар суугийн аль нэг хаант улсад томилогдоно. Зөв шударга хүмүүс Бурханы зарлигуудыг дуулгавартай дагадаггүй хүмүүсээс илүү агуу их баяр хөөр хийгээд адислалуудыг өвлөн авах болно (1 Коринт 15:35, 40–42-ыг үз).

1. Тэлэстиэл алдар суу нь Есүс Христийн сайн мэдээг хүлээн аваагүй буюу Есүсийн тухай болон Бурханы бошиглогчдын тухай гэрчлэлгүй, нүгэлтэй амьдралаар амьдардаг хүмүүст зориулагдсан (С ба Г 76:81–88, 98–103-ыг үз).
2. Тэррэстриэл алдар суу нь мэхлэгдсэн бөгөөд Есүс Христийн тухай гэрчлэл нь баттай биш дэлхийн хүндэтгэлтэй хүмүүст зориулагдсан байна (С ба Г 76:71–79-ийг үз).
3. Сэлэстиэл алдар суу нь зарлигуудыг дуулгавартай дагаж, ёслолуудыг хүлээн авч, аливаа зүйлсийг Есүс Христэд итгэх итгэлээр даван туулж, зүрх сэтгэлдээ цэвэр ариун болсон хүмүүст зориулагддаг (С ба Г 76:50–70-ыг үз).

Дараах асуултуудад хариулахыг ангийн гишүүдээс хүс:

- Авралын төлөвлөгөөний талаар өмнө нь мэддэггүй байсан ямар зүйлийг та нар мэдэж авсан бэ?
- Энэ агуу төлөвлөгөөн дэх Есүс Христийн үүргийн тухай бодоход та нарт ямар сэтгэгдэл төрдөг вэ?
- Тэдний төлөвлөгөөнд баяртай байдгаа бид Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрт хэрхэн харуулж болох вэ?

Авралын төлөвлөгөөн дэх Аврагчийн Цагаатгалын агуу их ач холбогдлыг онцлон тэмдэглэхийн тулд итгэлийн тунхагийн гуравдугаар зүйлийг гүйцээн зурсан хүснэгтийн доор энд харуулснаар бич.

Дүгнэлт

Ариун сүм нь бидний амьдралд агуу их адислалуудыг авчирдаг энэ төлөвлөгөөний тухай мэдлэгийг бидэнд хангаж өгдөг гэдгийг

онцлон тэмдэглэ. Та өөрөө авралын төлөвлөгөөг ойлгож, сайн мэдээний зарчмуудын дагуу амьдарснаар хүлээн авсан адислалуудынхаа талаар гэрчлэлээ хуваалц.

Та “Хүмүүн Аз Жаргалын Эрэлд”-ийг үзүүлж хичээлээ төгсгөж болно.

Хаалтын залбирал хийхийг хэн нэгнээс хүс.



“Сайн мэдээний хууль, ёслолуудыг дуулгавартай дагавал Христийн Цагаатгалаар бүх хүн төрөлхтөн аврагдах боломжтой гэдэгт бид итгэдэг” (Итгэлийн Тунхаг 1:3).



Бид Ариун Сүмд Орохын Тулд Зохистой Байх Ёстой

“Сүмийн гишүүн нэг бүрийг ариун сүмд орох зохистой байлгах нь миний чин хүсэл юм. Би насанд хүрсэн гишүүн нэг бүр зохистой байж, ариун сүмийн хүчинтэй зөвшөөрлийн бичигтэй байна гэж найдаж байна” (Ерөнхийлөгч Ховард В.Хантэр).

ЗОРИЛГО

Ариун сүмд орохуйц зохистой байх ёстой гэдгийг ойлгоход нь ангийн гишүүдэд тусална.

БЭЛТГЭЛ

1. Ариун сүмийн зөвшөөрлийн бичиг авах журмын талаар ярьж өгөхийг бишоп буюу салбарын ерөнхийлөгчөөс энэ хичээлийг орохоос нэлээд хугацааны өмнө урь. Энэ хичээлийг заахад зөвлөмж болгож байгаа материал нь 10–11-р хуудсан дахь “Ариун Сүмийн Зөвшөөрлийн Бичиг Хүлээн Авах Үйл Явц Бол Адислал Мөн” гэсэн хэсэгт байгаа. Хэрэв бишоп боломжгүй байгаа бол, та түүний зөвлөхүүдийн нэгээс танилцуулга хийж өгөхийг хүсч болно.
2. Дараах ишлэлийг самбар дээр эсвэл үзүүлэн дээр бич: “Их Эзэн Есүс Христийн амьдрал болон үлгэр жишээнд илүү их анхаарал тавьж амьдрахыг би бүх гишүүдэд уриалж байна” (President Howard W. Hunter, in Conference Report, Oct. 1994, 7; or *Ensign*, Nov. 1994, 8).

ХИЧЭЭЛИЙГ ЗААХ НЬ

Нээлтийн залбирал хийхийг хэн нэгнээс хүс.

Ямар нэгэн асуулт байгаа эсэхийг нь ангийн гишүүдээс асуу. Их Эзэний Сүнсээр удирдуулан мөн асуултуудад өөрийнхөө чадлаар хариулахад шаардлагатай цагийг зарцуул. Ариун сүмийн ажлын зарим зүйлүүдийг ариун сүмээс гадуур ярилцдаггүйг санагтун.

Ариун сүмд орж байгаа хүмүүс сайн мэдээний дагуу амьдарч, зарлигуудыг сахидгаараа Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрт итгэх итгэлээ харуулах ёстой гэдгийг тайлбарла. Тэд ёс суртахууны хувьд цэвэр ариун, аравны нэгийг бүрэн төлдөг, Мэргэн Ухааны Үгийг дуулгавартай дагадаг, Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахидаг, түүнчлэн бусад бүхий л талаар зөв шударгаар амьдрахыг хичээдэг байх ёстой. Мөн түүнчлэн тэд бишоп буюу салбарын ерөнхийлөгч, түүнчлэн гадасны буюу номлолын ерөнхийлөгчтэй ярилцлагад орж, ариун сүмийн зөвшөөрлийн бичиг авахуйц зохистойгоо тодорхойлуулсан байх ёстой. Энэ хичээл нь ангийн гишүүд ариун сүмд оро-

хуйц зохистойгоо амьдрахын тулд баримталбал зохих сайн мэдээний зарим зарчмууд болон зарлигуудыг нэгтгэн авч үздэг.

Ёс Суртахууны Цэвэр Ариун Байдал

Их Эзэн болон Түүний бошиглогчид ёс суртахууны хувьд цэвэр ариун байхын ач холбогдлыг дахин давтан заасаар байдгийг тайлбарла. Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли заахдаа: “Бид гэрлэлтийн өмнөх ариун явдал ба гэрлэлтийн дараа туйлын үнэнч байх явдалд итгэдэг. Энэ нь гэрлэлтийн үр дүн болдог. Энэ бол амьдрал дахь аз жаргалд хүрэх зам мөн. Энэ бол сэтгэл хангалуун байдалд хүрэх зам мөн. Энэ нь зүрх сэтгэлд амар амгаланг, гэр оронд амар амгаланг авчирдаг” (in Conference Report, Oct. 1996, 68; or *Ensign*, Nov. 1996, 49).

Дараах судруудыг хамтдаа унш:

Сургаал ба Гэрээ 42:22–24 (Эхнэр буюу нөхрөө хайрлаж бай, мөн өөр хэн нэгнийг эрэлхийлэх ёсгүй хэмээн Их Эзэн бидэнд зарлигласан билээ; садар самууныг үйлдэхгүй байхыг тэрээр бидэнд зарлигласан.)

Сургаал ба Гэрээ 121:45 (Их Эзэн бидэнд, “сайн сайхан [бидний] бодол санааг үргэлжид чимж байг.”)

1 Тимот 4:12 (Бид цэвэр ариун байдлын үлгэр дууриал байх ёстой.)

1 Нифай 10:21 (Цэвэр бус зүйл Бурхантай хамт оршиж эс чадна.)

Итгэлийн Тунхаг 1:13 (Бид цэвэр ариун, сайн санаатай байхад итгэдэг).

- Их Эзэн ёс суртахууны цэвэр ариун байдлыг яагаад ихэд онцлон тэмдэглэдэг вэ?

- Дэлхийд бид эргэн тойрондоо байгаа ёс суртахуунгүй байдлын зарим ямар үр дагаваруудыг харж болох вэ? Ёс суртахууны хувьд цэвэр амьдралаар амьдарснаар ирдэг зарим ямар адислалууд байдаг вэ?

Самбар дээр буюу үзүүлэн дээр бичиж бэлтгэсэн ишлэлд ангийн гишүүдийн анхаарлыг хандуул (энэ хичээлийн “Бэлтгэл” хэсгийг үз).

- Энэ зөвлөгөө дэлхийн уруу таталтуудыг эсэргүүцэж, ёс суртахууны хувьд цэвэр ариун амьдралаар амьдрахад бидэнд болон бидний үр хүүхдүүдэд хэрхэн тусалж чадах вэ?

Аравны Нэг

Сургаал ба Гэрээ 119:4-ийг уншихыг ангийн гишүүдээс хүс.

Зохих ёсны аравны нэгийн талаар Тэргүүн Зөвлөл дараах тайлбар хийснийг тэмдэглэн хэл: Их Эзэний өөрийнх нь хэлсэн үг, тухайлбал Сүмийн гишүүд орлого хэмээн нэрлэгддэг ‘жил тутмын ашгаасаа аравны нэгийг’ нь төлөх ёстой гэсэн тэрхүү туйлын энгийн мэдэгдлийг бид мэддэг” (First Presidency Letter, 19 Mar. 1970). Аравны нэгийн санг цуглааны байрууд, ариун сүмүүд барих, номлолын ажилд дэмжлэг үзүүлэх, түүнчлэн газар дэлхий дээр Бурханы хаант улсыг байгуулахад ашигладаг.

Ерөнхийлөгч Жэймс И.Фаустын дараах мэдэгдлийг хуваалц:

“Аравны нэг бол хувь хүний аз жаргал хийгээд дэлхий даяарх Сүмийн гишүүд баян, ядуу аль алиных нь сайн сайхан байдлын тулгуур зарчим мөн. Аравны нэг бол золиослолын зарчим бөгөөд тэнгэрийн цонхыг нээх түлхүүр мөн. . . . Аравны нэгээ төлдөггүй Сүмийн гишүүд гишүүнчлэлээ алддаггүй; тэд зөвхөн адислалуудаа алддаг” (in Conference Report, Oct. 1998, 73–74; or *Ensign*, Nov. 1998, 58–59).

Ангийн гишүүдийн хамт дараах судруудыг нэгтгэн дүгнэ:

Левит 27:30 (Аравны нэг бол Их Эзэнийх юм; энэ нь Их Эзэний хувьд ариун юм.)

Малахи 3:8–11 (Аравны нэгээ төлөхгүй байснаар бид Бурханыг дээрэмддэг; аравны нэгээ төлдөг хүмүүсийг Бурхан элбэг дэлбэгээр адисладаг.)

- Аравны нэгээ төлсний төлөө та нар ямар адислалуудыг хүлээн авсан бэ?
- Бид аравны нэгээ төлөхгүй байснаар Бурханыг яагаад дээрэмддэг вэ? (С ба Г 104:14-ийг үз.)

Жил болгон аравны нэгийн хэлэлцүүлгийн үеэр аравны нэгээ бүрэн төлдөг эсэхээ тогтоолгохоор бишоп эсвэл салбарын ерөнхийлөгчтэйгөө уулзаж ярилцлаганд орохыг гишүүдээс хүсдэгийг тайлбарла. Энэ уулзалт нь энэхүү чухал зарлигийг гишүүд хэрхэн биелүүлдгээ үнэлэх сайхан боломж юм.

Мэргэн Ухааны Үг

Биднийг ариун сүм рүү явахын өмнө сүнслэг байдал болон бие махбодийн аль алинаар нь бидний амьдралыг цэвэр бус мөн эрүүл бус болгодог дадал зуршлуудаасаа салсан байхыг Их Эзэн биднээс хүсэн хүлээдгийг тайлбарла.

Дараах судруудын хэсгийг эсвэл бүгдийг нь хамтдаа унш:

1 Коринт 3:16–17 (Бидний бие махбодь Бурханы ариун сүм бөгөөд бузарлагдсан байх ёсгүй.)

Сургаал ба Гэрээ 89 (Энэхүү илчлэлтийг Мэргэн Ухааны Үг гэдэг. 1–9-р шүлэг нь бид бие махбодидоо оруулж үл болох зүйлүүдийг өгүүлсэн байдаг; 10-17-р шүлэг бидний бие махбодид сайн зүйлүүдийн талаар өгүүлсэн байдаг; 18–21-р шүлэгт Их Эзэний зарлигуудыг сахидаг хүмүүст Түүний өгсөн амлалт байдаг.)

- Дэлхий дээрх ямар зүйлс биднийг өнөө үед Мэргэн Ухааны Үгэнд өгсөн зарлигуудыг зөрчихөд хүргэдэг вэ?
- Их Эзэний эрүүл мэндийн хуулиудыг сахин биелүүлэхэд бид өөрсөддөө болон хүүхдүүддээ хэрхэн тусалж чадах вэ?

Сургаал ба Гэрээ 29:34-ийг уншихыг ангийн гишүүдээс хүс.

- Мэргэн Ухааны Үг нь ямар байдлаар биднийг сүнслэг байдлын хувьд ч, бие махбодийн хувьд ч адислаж чадна гэж та нар боддог вэ?
- Эдгээр зарлигуудыг сахиснаар бид “мэдлэгийн ямар агуу их баялагийг” (С ба Г 89:19) хүлээн авч болох вэ?

Ерөнхийлөгч Боид К.Пакерын дараах мэдэгдлийг хуваалц

“Сүнслэг байдлын хувьд та нар юу сурнав, энэ нь та нар биеэ хэрхэн анхаарч тордохоос хамаарна. Мэргэн Ухааны Үг ихэд ач холбогдолтой байдгийн учир нь энэ юм.

“Илчлэлтээр хориглосон зуршил бий болгогч цай, кофе, архи, тамхи зэрэг бодисууд нь донтуулах бусад бодисын нэгэн адил сүнслэг харилцааны нарийн мэдрэмжүүдэд саад учруулж булингартуулдаг.

“Мэргэн Ухааны Үгийг хайхрахгүй байж болохгүй, учир нь энэ нь үүнийг сахидаг хүмүүст амлагдсан тэрхүү ‘нуугдмал үнэт зүйлс болох агуу үнэт мэдлэгийг’ танд их үнээр олдох болгож болно. Түүнчлэн сайн эрүүл мэндтэй байна гэдэг бол нэг адислал нэмж авч байгаа гэсэн үг юм” (in Conference Report, Oct. 1994, 78; or *Ensign*, Nov. 1994, 61).

Хүндэтгэлийн Өдөр

Египетээс Гарсан нь 20:8–11-ийг хамтдаа унш.

Их Эзэний хүмүүс Хүндэтгэлийн өдрийг ямагт ариунаар сахиж байхыг зарлигдуулсан байдгийг тайлбарла. Үүнийг хийдэг хүмүүст Их Эзэн агуу их адислалуудыг амласан байдаг.

Сургаал ба Гэрээ 59:9–13-ыг уншихыг ангийн гишүүдээс хүс.

- Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахихын тулд Их Эзэн ямар үндсэн учир шалтгаануудыг өгсөн бэ?
- Сургаал ба Гэрээний 59:9–13 нь Хүндэтгэлийн Өдрийг ямар байдлаар сахихад биднийг хөтөлдөг вэ?

- Хүндэтгэлийн өдрийг зохих ёсоор нь сахидаг хүмүүст ямар адислалууд амлагдсан байдаг вэ?

Энэ ярилцлагын нэг хэсэг болгон, Ахлагч Жэймс И.Фаустын заасан дараах зарчмуудыг хуваалц:

“Бурхан Хүндэтгэлийн өдөрт хүндэтгэлтэйгээр хандахыг биднээс яагаад хүсдэг вэ? Хамгийн багаар бодоход гурван учир шалтгаан бий гэж би боддог. Нэг дэх нь амрах хийгээд шинэ эрч хүч авах бие махбодийн хэрэгцээтэй холбоотой. . . .

“Хоёр дахь нь, миний бодлоор, бүр ч илүү ач холбогдолтой юм. Энэ нь бидний сүнсэн хүнийг сэргээн бэхжүүлэх хэрэгцээг хангахад хэрэгтэй юм. . . .

“Туравдахь шалтгаан нь энэ гурваас хамгийн чухал нь юм. Энэ нь Бурханыг хайрлах хайрын маань илэрхийлэл болсон, зарлигуудад дуулгавартай байх явдал юм. Аврагчийг хайрлах хайрынхаа учир түүний зарлигуудыг сахихаас өөр аливаа шалтгаангүй хүмүүс адислагддаг билээ” (in Conference Report, Oct. 1991, 46–47; or *Ensign*, Nov. 1991, 35).

- Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахисны хариуд та нарын амьдралд ямар адислалууд ирсэн бэ?

Өнөөдөр ярилцсан зарлигууд болох ёс суртахууны цэвэр ариун байдал, аравны нэг, Мэргэн Ухааны Үг түүнчлэн Хүндэтгэлийн өдрийг сахих явдлын дагуу амьдрахыг өөрсөддөө амлахыг ангийн гишүүдээс хүс. Ингэснээр тэд ариун сүмд ороход илүү сайн бэлтгэгдэж, Их Эзэний адислалуудыг илүү элбэг дэлбэгээр хүлээн авах болно.

Ариун Сүмийн Зөвшөөрлийн Бичиг Хүлээн Авах Үйл Явц Бол Адислал Мөн

Гишүүд ариун сүм рүү явахаасаа өмнө ариун сүмийн зөвшөөрлийн бичиг хүлээн авахуйц зохистойгоо тодорхойлуулах ёстойг тайлбарла. Дараах мэдэгдэлд тайлбарласанчлан, энэхүү зөвшөөрлийн бичгийг авснаар хүн болгоны амьдрал адислагдах болно:

“Бидний хувийн зохистой байдлын талаар асууж мэдэх үүрэг хариуцлагыг бишоп хүлээдэг. Сүмийн гишүүний хувьд энэ ярилцлага танд туйлын чухал ач холбогдолтой юм, учир нь энэ бол амьдралынхаа хэв маягийг Их Эзэний томилогдсон үйлчлэгчтэй хамтран тодорхойлж байгаа явдал юм. Хэрэв таны амьдралд ямар нэг буруу зүйл байвал, үүнийг тань шийдвэрлэхэд бишоп танд туслах болно. Энэ журмаар дамжуулан та Израилын олон нийтийн шүүгчтэй зөвшилцөж, Их Эзэний зөвшөөрөн баталснаар ариун сүмд ороход зохистойгоо нотлуулах буюу тогтоолгоход туслуулж болно” (*Ариун Сүмд Ороход Бэлтгэх нь*, 3).

“Би . . . Сүмийн гишүүдийг гишүүн байгаагийнх нь агуу их бэлэг тэмдэг мөн тэдний хамгийн нандин гэрээнүүдийн эрхэм дээд газар болсон Их Эзэний ариун сүмийг босгохыг урьж байна” (*Ерөнхийлөгч Ховард В.Хантэр*).

Ариун сүмийн зөвшөөрлийн бичиг анх удаа авах гэж байгаа болон ариун сүмд гэрлэхээр төлөвлөж байгаа бүх хүмүүстэй бишоп буюу салбарын ерөнхийлөгч түүнчлэн гадасны буюу номлолын ерөнхийлөгч ярилцлага хийдгийг тайлбарла. Ариун сүмийн зөвшөөрлийн бичгээ шинэчлэх гэж буй хүмүүстэй бишопын зөвлөл болон гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн зөвлөхүүд ярилцлага хийж болно.

Энэ үеэр ариун сүмийн зөвшөөрлийн бичгийн талаар ангийнханд зориулж танилцуулга хийхийг бишоп буюу салбарын ерөнхийлөгч, эсвэл бишопын зөвлөлийн зөвлөхүүдийн нэгээс хүс. Тэрээр ярилцлагын жинхэнэ асуултуудыг ангийнханд уншиж өгөх ёсгүй, харин ариун сүмийн зөвшөөрлийн бичгийн ярилцлагын үеэр ангийн гишүүд юу мэдвэл зохих талаар тодорхой санаануудыг заах ёстой. Чиглэл болгон дараах баримтлалуудыг ашиглаж болно:

Ариун сүмийн зөвшөөрлийн бичиг авах гэж байгаа гишүүд Тэнгэрлэг Эцэг, Их Эзэн Есүс Христ болон Ариун Сүнсний талаар гэрчлэлтэй байх ёстой. Тэд Их Эзэний бошиглогч,бусад Ерөнхий Эрх Мэдэлтнүүд болон орон нутгийнхаа Сүмийн удирдагчдыг дэмждэг байх ёстой. Сүмээс урвасан буюу номлол, үйл ажиллагаа нь сайн мэдээнд харшлагч хэсэг бүлэг буюу хувь хүмүүсийг тэд талархан дэмждэг буюу тэдэнтэй холбоотой байх ёсгүй.

Ариун сүмийн зөвшөөрлийн бичиг авах гэж байгаа хүмүүс ариун ёслолын цуглаанууд, санваартны цуглаан, мөн түүнчлэн Сүмийн бусад хурал цуглаануудад итгэлтэйгээр оролцдог байх ёстой. Тэд санваарын эрх мэдлээр дамжуулан өгсөн дуудлагуудаа ухамсартайгаар биелүүлдэг байх ёстой. Тэд Их Эзэний бүх зарлигуудыг сахидаг, түүний дотор аравны нэгээ бүрэн төлөх, үг хэл, үйл хэргээрээ үнэнч шударга байх, цай, кофе, архи, тамхи, түүнчлэн бусад хортой, муу зуршилд хөтлөгч бодисуудыг хэрэглэхгүй байхын төлөө хичээн чармайдаг байх ёстой.

Тэд цэвэр, ариун журамтай амьдарч, хууль ёсоор хуримласан эхнэр буюу нөхрөөсөө өөр хүнтэй бэлгийн харьцаанд орохыг хориглодог Их Эзэний ариун явдлын хуулийг сахидаг байх ёстой. Тэд гэр бүлийнхээ бусад гишүүдтэй сүнслэг байдал хийгээд ердийн харилцаа аль алинд нь сайн мэдээний зарчмуудад нийцүүлэн харьцах ёстой. Тэд сүнслэг байдал, бие махбодь, оюун санаа, сэтгэл хөдлөлийн хувьд бусадтай зүй бус харьцах ёсгүй.

Тэд нүгэлдээ гэмшиж, түүнийг бүрмөсөн орхиход бэлэн байх ёстой. Ёс суртахууны нүгэл хилэнц, гэр бүлийн гишүүдтэй зүй бус харьцах урвагч бүлэг буюу үйл ажиллагаатай холбоотой байх, улс орны хуулиудыг ноцтойгоор зөрчих зэрэг ноцтой хүнд нүглийг ариун сүмийн зөвшөөрлийн бичиг авахын өмнө бишоп буюу салбарын ерөнхийлөгчид ариун сүмийн зөвшөөрлийн бичиг олгох

ярилцлагаас нэлээд хугацааны өмнө гэмшин наманчлах ёстой. Христийн Гэрэл болсон хувь хүний ухамсар нь бүх хүмүүст хандан, тухайн хүн бишоп буюу салбарын ерөнхийлөгчтэй ямар нэг зүйлийн талаар хэлэлцэх ёстой гэсэн асуудал түүний оюун бодолд төрөх юм бол, энэ тухай зайлшгүй хэлэлцэх ёстой.

Гэр бүл салсан хүмүүс ариун сүмийн зөвшөөрлийн бичиг авахаас өмнө бишоп буюу салбарын ерөнхийлөгч түүнчлэн гадасны буюу номлолын ерөнхийлөгчийн өмнө гэмшиж, цэвэршсэн байх хэрэгтэй. Тэд гэр бүл салалтын гэрээнд, түүний дотор тухайн үед хүчинтэй байгаа тэтгэмжийн төлбөрүүдийг үргэлж шударгаар хийдэг байх ёстой.

Ариун сүмийн зөвшөөрлийн бичиг авах гэж байгаа гишүүд бишопын зөвлөлийн гишүүн буюу салбарын ерөнхийлөгчтэй ярилцлагад орсны дараа гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн буюу номлолын ерөнхийлөгчтэй ярилцлагад орох ёстой. Яагаад ингэх шаардлагатайд зарим хүмүүс гайхаж болох юм. Бид ариун сүмийн зөвшөөрлийн бичиг авахдаа ариун сүмд орохын тулд үнэндээ Их Эзэнээс зөвшөөрөл хүсдэг билээ. Их Эзэний эрх мэдэл бүхий үйлчлэгчид болох хоёр гэрчийн өмнө бид өөрсдийн зохистой байдлыг тодорхойлуулах онцгой боломжтой юм. Ариун сүмд орохуйц зохистой байдлаа Их Эзэний үйлчлэгчдийн өмнө жил бүр нотлуулна гэдэг нь бидний хувьд адислал мөн.


Дүгнэлт

Ариун сүмд орохуйц зохистой байж, ариун сүмийн хүчин төгөлдөр зөвшөөрлийн бичгийг ямагт авч явахын ач холбогдлыг онцлон тэмдэглэхийн тулд Ерөнхийлөгч Ховард В.Хантэрийн дараах мэдэгдлийг дүгнэн ярилц:

“Би . . . Сүмийн гишүүдийг гишүүн байгаагийнх нь агуу их бэлэг тэмдэг мөн тэдний хамгийн нандин гэрээнүүдийн эрхэм дээд газар болсон Их Эзэний ариун сүмийг босгохыг урьж байна. Сүмийн гишүүн нэг бүрийг ариун сүмд орох зохистой байлгах нь миний чин хүсэл юм. Би насанд хүрсэн гишүүн нэг бүр хэдийгээр ойрын ариун сүм нь байнга ороод байх боломжгүй хол байдаг ч гэсэн зохистой байж, ариун сүмийн хүчинтэй зөвшөөрлийн бичигтэй байна гэж найдаж байна” (quoted in Jay M. Todd, “President Howard W. Hunter,” *Ensign*, July 1994, 5).

Ариун сүмд орох зохистой байсны хариуд амьдралд чинь ирсэн адислалуудын тухай гэрчлэлээ хуваалц.

Хаалтын залбирал хийхийг хэн нэгнээс хүс.



АРИУН СҮМИЙН АЖИЛ БИДНИЙ АМЬДРАЛД АГУУ ИХ АДИСЛАЛУУДЫГ АВЧИРДАГ

“Таны үйлчлэгчид энэ өргөөнөөс таны хүчээр зэвсэглэн урагш одох болтугай хэмээн, мөн тэдэн дээр таны нэр байх болтугай хэмээн, мөн таны алдар суу тэдний эргэн тойронд байх болтугай хэмээн Ариун Эцэг танаасаа бид хүснэм”
(С ба Г 109:22)

ЗОРИЛГО

Ариун сүмд зохистойгоор орогчид Их Эзэнээс агуу их адислалууд хүлээж авах болно гэдгийг ойлгоход ангийн гишүүдэд тусална.

БЭЛТГЭЛ

1. Хичээл дээр судруудын тухай ярилцлага хийхэд бэлтгэлтэй байхын тулд энэ хичээлд ашиглах судруудыг анхааралтайгаар нягтлан үз.
2. Ариун сүмийн ажлын тухай эсвэл үнэний мөнхийн мөн чанарын тухай “Хэлээч Үнэнийг” (Сүмийн Дуулал Болон Хүүхдийн Дуунууд, х. 31) дууллыг ангийн гишүүдээр дуулуулахаар бэлтгэж болно.
3. Хэрэв *Family Home Evening Video Supplement 2* (53277) байгаа бол та “Temples Are for Eternal Covenants”-ийг үзүүлж болно.

ХИЧЭЭЛИЙГ ЗААХ НЬ

Нээлтийн залбирал хийхийг хэн нэгнээс хүс.

Ямар нэгэн асуулт байгаа эсэхийг нь ангийн гишүүдээс асуу. Их Эзэний Сүнсээр удирдуулан мөн асуултуудад өөрийнхөө чадлаар хариулахад шаардлагатай цагийг зарцуул. Ариун сүмийн ажлын зарим зүйлүүдийг ариун сүмээс гадуур ярилцдаггүйг санагтун.

АРИУН СҮМИЙН АЖЛЫГ ЭРТ ДЭЭР ҮЕЭС ХИЙСЭЭР БАЙГАА БИЛЭЭ

Та ариун сүмийн ажлын тухай буюу үнэний мөнхийн мөн чанарын тухай аль нэг дууллыг хамтдаа дуулж хичээлээ эхэлж болно.

Ариун сүмүүд барихыг Их Эзэн Өөрийн хүмүүст ямагт зарлигладгийг тайлбарла. Ариун сүмд хийгдэх ёстой ажлыг Тэрбээр илчилсэн билээ.

- Судруудад ямар ариун сүм буюу табэрнеклүүдийн тухай дурьдсан байдаг вэ?

Ариун сүм буюу табэрнеклүүдийн талаарх ишлэлүүдийг олохын тулд судрын индексүүдийг үзэхэд ангийн гишүүдийг урь. Ангийн гишүүдийн хариултуудыг самбар дээр жагсаан бичиж болно.

Түүнчлэн та дараах судруудыг нэгтгэн дүгнэж ярилцахыг ангийн гишүүдээс хүсч болно:

Мосегийн табэрнекл: Египетээс Гарсан нь 40:1–2, 34–38

Соломоны ариун сүм: Шастирын Дэд 3:1–2; 5:1

Херодын ариун сүм: Матай 21:12–15

Нифайчуудын ариун сүмүүд: 2 Нифай 5:16; Мозая 1:18;
3 Нифай 11:1

Урвалтын улмаас эдгээр бүх ариун сүмүүд эцэстээ жинхэнэ зорилгоо алдаж, устгагдсан юм гэдгийг тайлбарла. Ариун сүмийн ажил Бошиглогч Иосеф Смитээр дамжин, бидний амьдралд агуу их адислалуудыг авчирч, өнөө үед бүрэн байдлаараа сэргэсэн билээ.

Ахлагч Брүс Р.МакКонки хэлэхдээ: “Ариун сүмүүдийг сүнслэг урмаар барьж, зохих ёсоор нь хэрэглэх нь Их Эзэний ажлын тэнгэрлэг шинжүүдийг батлах агуу нотолгоонуудын нэг юм. . . . Илчлэлтийн сүнстэйгээр үйлдэж байгаа хүмүүс ариун сүмд байгаа газарт Их Эзэний хүмүүс байх болно; эдгээр нь байхгүй газарт Сүм, хаант улс болон тэнгэрийн үнэн байхгүй билээ” (*Mormon Doctrine*, 2nd ed. [1966], 781).

Ариун Сүмд Зохистойгоор Орогсдог Агуу Их Адислалууд Амлагддаг

Ариун сүм буюу Их Эзэний өргөө нь сэлэстиэл хаант улс дахь өргөмжлөлд бэлтгэхийн тулд бидний очдог газар юм. Тэнд бид Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын тухай илүү ихийг мэдэж авдаг. Бид Тэдэнтэй гэрээнүүдийг байгуулдаг бөгөөд Тэд гайхамшигтай сайхан адислалуудыг бидэнд амладаг билээ.

Сургаал ба Гэрээнд Их Эзэн, ариун сүмд орж, мөн тэнд хийсэн гэрээнүүдийн дагуу зохистой амьдрагчдад ирэх зарим адислалуудын тухай дүрслэн өгүүлсэн байдаг. Эдгээр адислалуудаас заримыг нь Көртландын Ариун Сүмийг онцгойлон адислахад хийсэн залбирал болох 109-р хэсэгт дүрсэлсэн байдаг. Уг залбирлын үгс Иосеф Смитэд илчлэлтээр өгөгджээ.

Ерөнхийлөгч Ховард В. Хантэр хэлэхдээ, “Их Эзэнээс бидэнд өгсөн санваарын хүчийг Түүний ариун сүмүүдэд ашигладаг учраас энэ залбирал нь бидэнд хувь хүмүүсийн хувиар, гэр бүлүүдийн хувиар, түүнчлэн хүмүүсийн хувьд бидэнд тасралтгүй хариулагдсаар байх болно” гэжээ (“The Great Symbol of Our Membership,” *Ensign*, Oct. 1994, 4).

Ерөнхийлөгч Хантер тэр үед 109-р хэсгээс зарим шүлгийг иш татжээ. Эдгээр шүлгүүдийг уншихыг ангийн гишүүдээс хүсч: Сургаал

ба Гэрээ 109:10–12, 22–23, 59, 67, 72, 75. Их Эзэний дурьдсан адислалуудыг эрэлхийлэхийг тэднээс хүс.

Уншсаных нь дараа тэдний мэдэж авсан адислалуудын жагсаалтыг гаргахыг ангийн гишүүдээс хүс. Тайлбаруудыг самбар дээр бич. Энд дурьдсан адислалуудад дараах зүйлүүд орж болно:

1. Их Эзэний алдар суу Түүний хүмүүс дээр ирэх болно.
2. Их Эзэний үйлчлэгчид Их Эзэний хүч, нэр, алдар суутайгаар ариун сүмээс гарч явах болно; мөн сахиулсан тэнгэрүүд тэднийг хариуцах болно.
3. Их Эзэний үйлчлэгчид сайн мэдээний үнэнийг ариун сүмээс газар дэлхийн өнцөг булан бүрт аваачих болно.
4. Их Эзэний хүмүүс цугларахын тулд гадаснууд зохион байгуулагдах болно.
5. Тараагдсан Израилынхан бүгдээр үнэнийг мэдэж, баясан цэнгэх болно.
6. Гэгээнтнүүдийн гэр бүлүүд болон тэдний өвдөгсөд хийгээд шаналан зовогсод Их Эзэний өмнө дурсан санагдах болно.
7. Их Эзэний хаант улс бүх дэлхийг дүүргэх болно.
8. Нэгэн цагт Их Эзэний үйлчлэгчид Их Эзэнийг угтахаар цугларч, түүнтэй хамт үүрд байх болно.

“Тийм ээ, мөн бибээр байх [өөрийн өргөөнд] болно, учир нь үүнд би ирэх болно, мөн зүрх сэтгэлдээ цэвэр ариун бүхэн Бурханыг үзэхээр үүн рүү ирэх болно” (С ба Г 97:16).

- Ариун сүмд зохистойгоор орж, гэрээнүүдээ хүндэтгэн сахидаг хүмүүст амлагдсан эдгээр гайхамшигт адислалуудын талаар та нар юу гэж боддог вэ?

Ерөнхийлөгч Ховард В.Хантер хэлэхдээ: “Ийм сэтгэл хөдөлгөм хийгээд гайхамшигт амлалтууд хүлээсэн хүмүүс урьд өмнө нь байсан болов уу! Дагалдагчид нь өөрсдийгөө Түүний үлгэр жишээ болон ариун сүмүүдэд төвлөрүүлэн чиглүүлэхийг Их Эзэн хүсдэгт гайхах юун” гэжээ (*Ensign*, Oct. 1994, 5).

Их Эзэн Сургаал ба Гэрээний 97-д ариун сүмүүдтэй холбоотой амлалтуудыг өгсөн байдаг. Сургаал ба Гэрээ 97:15–21-ийг уншихыг ангийн гишүүдээс хүс.

- Их Эзэний ариун сүмүүдэд Түүний адислалуудыг хүртэхийн тулд Их Эзэний хүмүүс юу хийх ёстой талаар 15–17-р шүлгүүд юу гэж заадаг вэ? (Зүрх сэтгэлдээ цэвэр ариун мөн ариун сүмүүдэд ямар нэг цэвэр бус зүйл оруулахгүй байх.)

Зүрх сэтгэлээрээ цэвэр ариун хүмүүсийг Сион хэмээн нэрлэдэг гэдгийг тайлбарла. Ариун сүмд зохистойгоор орж, зүрх сэтгэлдээ цэвэр ариун байж, муу ёрын сүнсээр бузарлагдахгүй байхыг

хичээснээр Сионыг байгуулахад бид тусалж чадах тухай 15-21-р шүлгүүд заадаг.

- Сион гэж нэрлэгдэхээр зохистой хүмүүст эдгээр шүлгүүдэд ямар адислалууд амлагдсан байдаг вэ?

Эрт дээр үед Сион хэмээх хот оршиж байсныг тайлбарла. Энэ хотыг бошиглогч Инок болон түүний хүмүүс байгуулжээ. Хүмүүс нь зөв шударга байсан учир энэ хот тэнгэрт зөөгдөн аваачигджээ (С ба Г 38:4; Мосе 7:18–21, 69-ийг үз).

Сион хожмын үед ч мөн байх болно. Итгэлийн аравдугаар тунхагт Сион хэмээх хот Америк тивд баригдах болно хэмээн Их Эзэн амласан байдаг. Итгэлийн энэ тунхагийг уншихыг ангийн гишүүдээс хүс. Израилын тараагдсан хүмүүс энэ агуу их хотод цугларах болно гэдгийг тайлбарла (С ба Г 103:11–13-ыг үз).

Өнөө үед, ариун сүмд орохоор зохистой болох хийгээд дэлхийн хаана ч амьдарч байлаа гэсэн Сионыг барьж байгуулахыг сүмийн гишүүдэд зөвлөж байгаа билээ. Бид гэр орноо ариун сүм мэт цэвэр ариун байдлын, хайрын мөн хувийн илчлэлт хүлээн авах газар болгох ёстой.

- Зүрх сэтгэлдээ илүү цэвэр ариун болохын тулд бид юу хийж чадах вэ?
- Зүрх сэтгэлдээ цэвэр ариун байх байдлыг дэлхий заримдаа ямар байдлаар хүндрүүлдэг вэ?
- Та нар гэр бүл, салбар буюу хэсэгтээ зүрх сэтгэлээрээ цэвэр ариун болоход нь ямар замаар тусалж болох вэ?

Ариун сүмийн гэрээнүүдийг байгуулж, сахидаг, түүнчлэн бүх амьдралынхаа туршид зүрх сэтгэлээрээ цэвэр ариун болохыг эрмэлздэг хүмүүс Сионыг байгуулахад тусалж чадна гэдгийг тайлбарла.

Дүгнэлт

Ариун сүмүүдэд зохистойгоор орогсод агуу их адислалуудыг, түүний дотор Сионы хүмүүс байх адислалуудыг Их Эзэнээс хүлээн авах болно гэдэг талаар гэрчлэлээ хуваалц. Бид эдгээр адислалуудыг хүлээн авахаар зохистой байж, зүрх сэтгэлээрээ цэвэр ариун болохын тулд хийж чадах бүхнээ хийх ёстой.

Та “Temples Are for Eternal Covenants” видео танилцуулгыг үзүүлж болно.

Хаалтын залбирал хийхийг хэн нэгнээс хүс.



АРИУН СҮМИЙН ЁСЛОЛУУД БОЛОН ГЭРЭЭНҮҮДИЙГ ХҮЛЭЭН АВАХ НЬ

“Тэдгээрийн
ёслолуудгүйгээр,
мөн санваарын
эрх мэдэлгүйгээр
бурханлаг чана-
рын хүч нь махан
бодит хүмүүнд
илэрдэггүй билээ”
(С ба Г 84:21).

ЗОРИЛГО

Ариун сүмийн ёслолууд болон гэрээнүүдийн чухал ач холбогдлыг ойлгоход ангийн гишүүдэд тусална.

БЭЛТГЭЛ

1. Хэрэв танай бүс нутагт *Together Forever* (53411) видео танилцуулга байгаа бол та үүнийг үзүүлж болно. Уг танилцуулга 27 минут орчим үргэлжилдэг.

ХИЧЭЭЛИЙГ ЗААХ НЬ

Нээлтийн залбирал хийхийг хэн нэгнээс хүс.

Ямар нэгэн асуулт байгаа эсэхийг нь ангийн гишүүдээс асуу. Их Эзэний Сүнсээр удирдуулан мөн асуултуудад өөрийнхөө чадлаар хариулахад шаардлагатай цагийг зарцуул. Ариун сүмийн ажлын зарим зүйлүүдийг ариун сүмээс гадуур ярилцдаггүйг санагтун.

Ариун Сүмд Бид Ёслолуудыг Хүлээн Авч мөн Гэрээнүүдийг Байгуулдаг

Бурханы дэргэд буцаж очих боломжийг бидэнд олгодог ёслолуудыг бид ариун сүмд хүлээж авдгийг тайлбарла. Мөн түүнчлэн бид сайн мэдээний хуулиудын дагуу амьдрах гэрээнүүдийг байгуулдаг. Дараах материал нь ёслолууд хийгээд гэрээнүүдийн тухай ерөнхий мэдээллээр, ялангуяа ариун сүмийн ёслолууд болон гэрээнүүдийн талаарх өвөрмөц мэдээллээр хангах болно.

Ёслолууд

Ёслол бол сүнслэг утга учир хийгээд үр нөлөө бүхий ариун нандин ёслол ном гэдгийг тайлбарла.

Сүм дэх ёслолуудаас заримыг нь нэрлэхийг ангийн гишүүдээс хүс. (Тэд хүүхдүүдийг нэрлэх ба адислах, баптисм, гишүүний баталгаа, ариун ёслол, санваарт томилох болон ариун сүмийн ёслолуудыг нэрлэж болно.)

Санваарын хүчээр гүйцэтгэгддэг ёслолууд нь бидний мөнхийн өргөмжлөлд зайлшгүй чухал ном гэдгийг тайлбарла. Эдгээр ёслолуудаар дамжуулан бид Бурханы хүчийг амьдралдаа хүлээн авдаг билээ.

Сургаал ба Гэрээний 84:19–21-ийг уншихыг ангийн гишүүдээс хүс.

- Бурханлиг чанарын хүч бидний амьдралд байхын тулд юу зайлшгүй чухал вэ? (Мелкизедек Санваарын ёслолууд. Эдгээр шүлгүүдэд дурдсан “санваарын илүү агуу зэрэг” бол Мелкизедек Санваар юм.)

“Бид цаг хугацаа, мөнгө, авьяас билгийнхээ нөөцийг өөрсдийгөө түүнчлэн эзэмшдэг бүхнээ газар дэлхий дээрх Бурханы хаант улсын ашиг сонирхлын төлөө зориулахаар гэрээнд орсон билээ”(Ариун Сүмд Ороход Бэлтгэх нь, 35).

Ариун Сүмд Ороход Бэлтгэх нь-ийн 29-р хуудсыг ангийн гишүүдээр гаргуул. Дараах мэдэгдлийг чангаар уншихыг ангийн нэг гишүүнээс хүс:

“Сүмийн гишүүдийн хувьд бидэнд ёслолууд хэр их чухал вэ?

“Тэдэнгүйгээр та нар аз жаргалтай байж мөн гэтэлгэгдэж мөн өргөмжлөгдөж чадах уу? Хариулт: Эдгээр ёслолууд нь зөвлүүштэй мөн хүсүүштэйгээс ч илүүтэйгээр, бүр зайлшгүй чухал юм. Тэр ч байтугай зайлшгүй чухал буюу амин чухал гэдгээс ч илүү эрхэм юм. Тэдгээр нь бид бүхний хувьд *шийдвэрлэгч ач холбогдолтой* юм.”

Гэрээнүүд

Гэрээ бол Бурхан болон нэг хүний эсвэл хэсэг хүмүүсийн хоорондох ариун нандин зөвшилцөөн юм гэдгийг онцлон тэмдэглэ. Бурхан тусгай нөхцөлүүдийг тогтоож, бид эдгээр нөхцөлүүдийг дуулгавартай дагавал биднийг адислахаар Тэрээр амладаг. Бид гэрээнүүдийг сахихгүй байхаар сонгосон үед, бид адислалуудыг хүлээн авч чадахгүй бөгөөд зарим тохиолдолд дуулгаваргүй байсныхаа улмаас шийтгэл амсдаг. Санваарын аврагч ёслолуудыг гэрээнүүд ямагт дагалддаг билээ.

- Та нар одоогийн байдлаар амьдралдаа Их Эзэнтэй ямар гэрээнүүд байгуулсан бэ? (Бид ариун ёслолоос хүртэх бүрд шинэчлэгдэж байдаг баптисмын гэрээг ангийн гишүүд дурдаж болох юм.)
- Бид усаар батлуулахдаа ямар гэрээнүүдийг байгуулдаг вэ? (Мозая 18:8–10; С ба Г 20:37-г үз.)

Бид Бурхантай гэрээ хийснээр Бурханд үйлчлэх хүсэл эрмэлзэл хийгээд биднээс хийхийг хүсдэг бүхнийг дуулгавартай дагахад бэлэн байгаагаа илэрхийлж байгаа хэрэг гэдгийг онцлон тэмдэглэ. Үүний хариуд Бурхан олон гайхамшигт адислалуудыг бидэнд амладаг билээ. Мөнх амьдрал өөд дэвшихийн тулд бид гэрээнүүдийг байгуулж, тэдгээрийг сахих ёстой.

Ариун Сүмийн Ёслолууд ба Гэрээнүүд

Ариун сүмийн ёслолуудад амьд байгаа хүмүүс болон нас барагсдын аль алинд нь зориулсан индаумент болон холболтууд (ариун сүмийн гэрлэлт болон эцэг эхчүүдийг хүүхдүүдтэй нь холбох) ордог гэдгийг тайлбарла. Нас барагсдын төлөө хийх баптисмын

ёслолыг санваарын бусад ёслолуудын адилаар ариун сүмүүдэд гүйцэтгэдэг. Ариун сүмийн ёслолуудад бид өөрсдийгөө Бурхан хийгээд газар дэлхий дээрх Түүний хаант улсыг байгуулахад туслахаар чанд гэрээнүүдийг байгуулдаг.

Ахлагч Э.Талмаж индаументад бидний хийдэг гэрээнүүдийн талаар хэлэхдээ:

“Индаументийн ёслолууд нь ариун журам хийгээд ариун явдлын хуулийг чанд сахих, энэрэнгүй, нинжин сэтгэлтэй, гэвчээртэй бөгөөд цэвэр ариун байх; авьяас билиг хийгээд эд материалын зүйлсийн аль алиныг нь үнэнийг дэлгэрүүлэх болон улс үндэстнээ дэвжээн өөд татахад зориулах; түүнчлэн өөрийн Хаан, Их Эзэн Есүс Христийг хүлээн авахад газар дэлхийг бэлэн болгох тэр агуу их бэлтгэлд хувь нэмрээ оруулах бүхий л арга замыг эрэлхийлэхээр гэрээ байгуулж, амлалт авах зэрэг тодорхой үүргүүдийг хувь хүнд ноогдуулдаг. Гэрээ бүрийг хийж, түүнчлэн үүрэг бүрийг хүлээснээр, гэрээний нөхцөлүүдийг итгэлтэйгээр сахихаас хамааран амлагдсан адислал тунхаглагддаг билээ” гэжээ (*The House of the Lord*, rev.ed. 84).

Гэрээнүүдийг самбар дээр бичиж, нэгтгэн дүгнээд ярилцаж болно. Бид зөв шударга, цэвэр ариун байхын тулд гэрээнүүдийг байгуулдаг бөгөөд түүнчлэн бид өөрсөддөө байгаа бүхнийг Их Эзэний хаант улсыг байгуулахын төлөө зориулахаар гэрээнүүд хийдгийг онцлон тэмдэглэ. Дараах мэдэгдлийг унш:

“Бид бол гэрээт хүмүүс. Бид цаг хугацаа, мөнгө, авьяас билгийнхээ нөөцийг бид бүгд өөрсдийгөө, түүнчлэн эзэмшдэг бүхнээ газар дэлхий дээрх Бурханы хаант улсын ашиг сонирхлын төлөө зориулахаар гэрээнд орсон билээ” гэсэн (*Ариун Сүмд Ороход Бэлтгэх нь*, 35).

- Бид ямар арга замаар “өөрсдийгөө, мөн түүнчлэн эзэмшдэг бүхнээ” Бурханы хаант улсад зориулж чадах вэ?
- Байгаа бүхнээ Их Эзэний хаант улсад зориулахад зарим үед ямар зүйлс гишүүдэд саад болдог вэ?

Ариун сүмийн гэрээнүүдийг байгуулж, сахисны учир таны амьдралд ирсэн адислалуудын талаар та өөрийнхөө гэрчлэлийг хуваалцаж болно. Эсвэл индаумент хүртсэн өөр нэг хүнээр гэрчлэлийг нь хуваалцуулахаар урьж болно.

Бид Ариун Сүмд Байгуулсан Гэрээнүүддээ Итгэлтэй Байх Ёстой
“Хэнд их нь өгөгдсөн байна, түүнээс ихийг шаардана” хэмээн Их Эзэн хэлснийг тайлбарла (Лук 12:48).

- Энэ шүлэг ариун сүмд бидний байгуулсан гэрээнүүдтэй хэрхэн холбогддог гэж та нар бодож байна вэ?

Их Эзэн өөрийн хүүхдүүдийг энэ амьдралын зорилгыг ойлгож, мөнх амьдралын алдар суугийн тэрхүү боломжид бэлтгэгдсэн байг хэмээн ариун сүмийн ёслолууд болон гэрээнүүдээр хангасныг тайлбарла. Бид эдгээр адислалуудыг хүлээн авснаараа мэдлэг, боломжуудаа дээшлүүлэн зохистой амьдрах хариуцлага хүлээдэг. Бид ариун сүмд хийсэн гэрээнүүддээ итгэлтэй байх ёстойг тайлбарла.

- Бид ариун сүмд хийсэн гэрээнүүддээ итгэлтэй байх нь яагаад туйлын их ач холбогдолтой вэ?

Сургаал ба Гэрээ 82:10-ыг уншихыг ангийн гишүүдээс хүс

“Их Эзэн, бибээр, миний хэлснийг та нар хийвэл үүрэг хүлээх болно; харин миний хэлснийг та нар хийхгүй бол, та нарт амлалт байхгүй болно” (С ба Г 82:10).

Ерөнхийлөгч Жозеф Филдинг Смит хэлэхдээ: “Хэрэв бид гэрээг үл сахиваас *Их Эзэн үүрэг хүлээх нь үгүйг* би та нарт хэлнэ. Их Эзэн гэрээгээ хэзээ ч зөрчдөггүй. Тэрээр бидний хэн нэгэнтэй гэрээ хийхдээ, үүнийг зөрчих нь үгүй. Хэрэв гэрээ зөрчигдөх аваас бид л үүнийг зөрчинө. Харин гэрээ зөрчигдөх аваас тэрээр бидэнд адислал өгөх үүрэггүй болж, бид үүнийг хүлээж авахгүй” гэжээ (*Doctrines of Salvation*, Bruce R. McConkie, 3 vols. [1954–56], 2:256–57).

Гэрээнүүддээ Итгэлтэй Байх нь Амар Амгалан, Аюулгүй Байдлыг Авчирдаг

Зовлонг дэлхийд ариун сүм бол амар амгалангийн болон ариун шүтээний газар мөн гэдгийг тайлбарла. Бид ариун сүмд тогтмол орж гэрээнүүддээ үнэнч итгэлтэй байвал, амьдралдаа амар амгалан, аюулгүй байдал хийгээд зорилго чиглэлийг олох болно.

Ахлагч Нил А.Максвелл хэлэхдээ, “Хэрэв бид гэрээнүүддээ сахих аваас, гэрээнүүд биднийг оюун санааны хувьд аюулгүй байлгах болно” гэжээ (in *Conference Report*, Apr. 1987, 87; or *Ensign*, May 1987, 71).

- Та нарын хийсэн гэрээнүүд та нарыг ямар байдлаар оюун санааны хувьд аюулгүй байхад тусалдаг вэ?

Ариун сүмд бид Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийн дэргэд эргэж очихын тулд зохистой амьдрах гэрээ хийдэг. Зарим үед, өдөр тутмын тэмцлийнхээ дунд бид ийм амьдрал боломжтой гэж үү хэмээн гайхах үе байдаг.

1 Нифай 17:3, 13-ыг уншихыг ангийн гишүүдээс хүс.

- Бид Түүнд эргэж очихын тулд хичээн чармайхад Их Эзэн хэрхэн тусалдаг тухай эдгээр судрууд юу заадаг вэ? Амьдралд тань эдгээр судрууд хэрэгжсэнийг та нар хэрхэн харж байна вэ?

Ахлагч Боид К.Пакер хэлэхдээ: “Та нар ариун сүмд ирж, өөрсдийнхөө индаументийг хүртэн, тахилын ширээний дэргэд өвдөг сөгдөн холболт хийлгэхдээ, ердийн амьдралаар амьдарч, уруу

таталтын эсрэг тэмцэн, алдаа гаргаж бас наманчилж, бас дахин алдаж, мөн наманчлагч ердийн бодгаль байдаг хэдий ч, гэрээнүүдээ сахихад ямагт шийдвэр төгс байдаг. . . . Дараа нь нэгэн өдөр та нар: ‘Сайн байна, итгэмжит сайн зарц минь: чи цөөн юманд итгэмжтэй байсан тул би чамд ихийг хариуцуулъя; Эзэнийхээ баяр баясгаланд ор’ хэмээх адислалыг хүлээн авах болно” (Матай 25:21) гэжээ (*Let not Your Heart Be Troubled* [1991], 257).

“Ариун сүмийн шүтээний хувийн адислалын төлөө эдгээр эрхэм ариун хийгээд ариулагдсан ханануудын дотор байдаг ариун гэгээн хийгээд аюулгүй байдлын төлөөнөө биднийг ариун сүм рүү олон-таа явахыг Ерөнхийлөгч Ховард урьсан байдаг. Ариун сүм бол үзэсгэлэн төгөлдрийн газар мөн, энэ бол илчлэлтийн газар мөн, энэ бол амар амгалангийн газар мөн. Энэ бол Их Эзэний өргөө юм. Энэ нь Их Эзэнд ариун бөлгөө. Энэ нь бидэнд ариун байх ёстой” (quoted in Jay M. Todd, “President Howard W. Hunter,” *Ensign*, July 1994, 5).

Дүгнэлт

Ариун сүмийн ёслолуудыг хүлээн авч Тэнгэрлэг Эцэгтэй гэрээ байгуулснаас ирэх адислалуудын талаар санаа бодлоо хуваалцалцыг ангийн гишүүдээс хүс.

Хэрэв цаг байвал түүнчлэн *Together Forever* видео танилцуулга тантай бүс нутагт байгаа бол та уг танилцуулгыг үзүүлж болно.

Ариун сүмийн ёслолууд хүлээн авснаас ирдэг адислалуудын тухай хийгээд Тэнгэрлэг Эцэгтэй гэрээнд орох онцгой боломжийн талаарх гэрчлэлээ хуваалц.

Хаалтын залбирал хийхийг хэн нэгнээс хүс.



БЭЛЭГ ТЭМДГҮҮДЭЭР ДАМЖУУЛАН ИХ ЭЗЭНЭЭС СУРАЛЦАХ НЬ

*“Хүмүүний үрст
би үе үеэр нь, зар-
чим зарчмаар нь
бага багаар энд
тэнд өгөх болно;
мөн миний зарч-
муудыг сонссон
тэд адислагдах
болой” (2 Нифай
28:30).*

ЗОРИЛГО

Ариун сүмд бэлэг тэмдгүүдийг ашигласан байдлыг үнэлж, ойлгоход ангийн гишүүдэд тусална.

БЭЛТГЭЛ

1. Өөрийнхөө орны төрийн далбааг эсвэл далбааныхаа зургийг авчир.
2. Ариун сүмийн гарментын талаарх асуултад Ах нарын нэг нь хэрхэн хариулсан тухай болсон явдлыг дүгнэж ярихыг ангийн нэг гишүүнээс хүс. Уг түүх *Ариун Сүмд Ороход Бэлтгэх нь* товхимолын 20–21 ба 23-р хуудсанд байгаа.

Багшийн анхааралд: Ариун сүмийн ёслолууд болон гэрээнүүд нь ариун нандин юм, тэдгээрийн талаарх ярилцлага нь үндсэндээ ариун сүмийн дотор ярилцахаар хязгаарлагддаг. Тийм учраас, ангид ярилцах нь ч гэсэн энэ гарын авлага дахь тайлбараар хязгаарлагдах ёстой.


ХИЧЭЭЛИЙГ ЗААХ НЬ

Нээлтийн залбирал хийхийг хэн нэгнээс хүс.

Ямар нэгэн асуулт байгаа эсэхийг нь ангийн гишүүдээс асуу. Их Эзэний Сүнсээр удирдуулан мөн асуултуудад өөрийнхөө чадлаар хариулахад шаардлагатай цагийг зарцуул. Ариун сүмийн ажлын зарим зүйлүүдийг ариун сүмээс гадуур ярилцдаггүйг санагтун.

Бидний Өдөр Тутмын Амьдралд Бэлэг Тэмдгүүд Чухал Ач Холбогдолтой Байдаг

Бидний өдөр тутмын амьдралд бэлэг тэмдгүүд байнга хэрэглэгддэгийг тайлбарла. Дараах буюу өөр зохих бэлэг тэмдгүүдийг самбар дээр зур. Бэлэг тэмдэг бүр ямар утга санаа илэрхийлж байгааг ангийн гишүүдээс асуу.



Өөрийнхөө орны төрийн далбаа буюу далбааныхаа зургийг ангийнханд үзүүлж, далбаа юуг дүрслэн харуулж байгааг тэднээс асуу.

- Эх оронч үзлийг харуулах өөр ямар зүйлүүд буюу үйл ажиллагаа байж болох вэ? (Дуу, дүрэмт хувцас, өмсгөл, баяр ёслол буюу тэмдэглэлт үйл явдал.)

Эдгээр нь эх оронч үзлийг илэрхийлэгч бэлэг тэмдгүүд юм гэдгийг онцлон тэмдэглэ.

- Хайр, хүндэтгэлийн ямар ямар бэлэг тэмдгүүд байдаг вэ? (Бэлэг буюу бөгж, үнсэх буюу тэврэх, зүрхний хэлбэртэй дүрс.)
- Бэлэг тэмдгүүд бүх хүмүүст адил утга санааг илэрхийлдэг үү? Яагаад тэгдэг эсвэл тэгдэггүй вэ?
- Бид яагаад бэлэг тэмдгүүдийг ашигладаг вэ?

Ярилцах боломжийг ангийн гишүүдэд олго. Тэд дараах санаануудыг гарган хэлж болно.

1. Бэлэг тэмдгүүд нь чухал зүйлсийн тухай санахад бидэнд тусалдаг.
2. Бэлэг тэмдгүүд нь өөр хэлбэрээр ойлгоход хэцүү хийсвэр үнэнүүдийг бидэнд заахад тусалж чадна.
3. Бэлэг тэмдгүүд санаа бодлыг илэрхийлж чадна.
4. Бэлэг тэмдгүүд нь бидний хувь хүний сурахад бэлэн байдлын дагуу өөр өөр зарчмуудыг заадаг билээ.

Бэлэг тэмдгүүд давтагдахад бид тэдгээрийг илүү сайн ойлгож авдаг гэдгийг тайлбарла.

Есүс Христ болон Түүний Бошиглогчид Бэлэг Тэмдгүүдийг Ашигладаг Байв

Аврагч зааж сургаж байхдаа бэлэг тэмдгүүдийг ахин давтан хэрэглэдэг байсныг тайлбарла.

- Их Эзэн бэлэг тэмдгүүдийг ашиглан зааж байсан зарим ямар жишээ байдаг вэ?

Алдагдсан хонь (Матай 18:12–14-ийг үз), гичний үр (Матай 13:31–32); эсвэл агуу их үнэт сувд (Матай 13:45–46-г үз) мэтийн зүйлсийг ангийн гишүүд дурдаж болно.

- Аврагч зааж сургах үедээ бэлэг тэмдгүүдийг яагаад ашигладаг байсан гэж та нар боддог вэ?

Ярилцах боломжийг ангийн гишүүдэд олго. Дараа нь доорх мэдэгдлийг нэгтгэн дүгнэж ярилц:

“Их Эзэн, Эзэн Багш Өөрөө шавь нартаа заадаг байсан номлолдоо сургаалт зүйрлэлүүдээр буюу өөр аргаар заахад ойлгоход хэцүү зүйлүүдийг бэлэг тэмдгээр төлөөлүүлж ярих аргаар заадаг байлаа. Тэрээр шавь нарынхаа амьдралаас авсан нийтлэг жишээнүүдийн талаар ярьдаг байв; мөн Тэрээр эм тахиа болон дэгдээхий, шувуу, цэцэг, үнэг, мод, дээрэмчин тонуулчид, нар жаргалт, баячууд ба ядуусын . . . тухай ярьсан байдаг. Гичний үр, сувдны тухай Тэрээр ярьсан байдаг. Тэрээр сонсогчиддоо заахыг хүсэн энгийн юмнуудын талаар бэлэг тэмдгийн байдлаар ярьдаг байв. Эдгээр зүйлсийн аль нь ч учир битүүлэг буюу ойлгомжгүй юм биш, харин эд бүгдээрээ бэлэг тэмдгийн шинжтэй юм” (*Ариун Сүмд Ороход Бэлтгэх нь*, 8).

Бошиглогчид болон төлөөлөгчид Есүс Христ ба түүний цагаатгагч золиослолын тухай заахдаа бэлэг тэмдгүүдийг олонтаа ашигладгийг тайлбарла. Есүс Христийн цагаатгал бол сайн мэдээний хийгээд бидний хүлээн авдаг бүх адислалын үндэс юм. Энэ цагаатгал нь авралыг авчирдаг. Тийм учраас, судрууд дахь бэлэг тэмдгүүдийн ихэнх нь Аврагчийн тухай, Түүний золиослолын тухай бидэнд заадаг.

Мосе 6:63-ыг уншихыг ангийн гишүүдээс хүс.

- Газар дэлхий дээрх ямар зүйлүүд Аврагчийн тухай гэрчилдэг вэ?

Алма 13:16-г уншихыг ангийн гишүүдээс хүс.

- Санваарын ёслолууд ямар байдлаар Аврагчийн тухай гэрчилдэг вэ?

Аврагч Цагаатгалыг хийхээс өмнө Түүний гэрээт хүмүүс цагаатгах золиослолынх нь бэлэг тэмдэг болгон амьтдыг золиослодог байсан гэдгийг цохон тэмдэглэ (Мосе 5:4–8-ыг үз). Энэ үйл Аврагчийн үхэл, Амилуулалтаар төгссөн. Одоо Их Эзэн бидэнд, “харууссан зүрх гэмшсэн сэтгэлийг [Түүнд] тахил болгон өргөх болно” (3 Нифай 9:20) гэж зарлигладаг. Мөн санваарын ёслолууд нь Аврагчийн цагаатгах золиослолыг дурсан санахад тусалсаар байдаг. Ахлагч Рассел М.Нэлсон заахдаа:

“Сайн мэдээний зайлшгүй шаардлагатай ёслолууд нь Цагаатгалыг бэлэгддэг. Усанд умбуулалтаар хийдэг баптисм нь үхэл, оршуулга хийгээд Гэтэлгэгчийн Амилуулалтын бэлэгдэл юм. Ариун ёслолоос хүртэх нь баптисмын гэрээнүүдийг мөн түүнчлэн Аврагчийн эвдэгдсэн махан бодь хийгээд бидний төлөө Тэрээр цусаа урсгасныг дурсан санах явдлыг шинэчилдэг билээ. Ариун сүмийн ёслолууд нь Их Эзэнтэй эвлэрэх бидний эвлэрэлтийг бэлэгдэн, гэр бүлүүдийг үүрд хамтад нь лацдан холбодог” гэсэн (in Conference Report, Oct. 1996, 47; or *Ensign*, Nov. 1996, 35).

Хэрэв Бид Сүнслэг Байдалд Мэдрэмтгий Байх Юм бол Бэлэг Тэмдгүүд Бидэнд Үнэнийг Заадаг

Аврагчийг дэлхий дээр амьдарч байхад шавь нар нь Тэрээр яагаад сургаалт зүйрлэлүүдээр заадгийг Түүнээс асуужээ. Сургаалт зүйрлэлүүд бол бэлэг тэмдгийн хэлийг олонтаа ашиглан, чухал ач холбогдол бүхий үнэнийг заадаг түүхүүд юм. Аврагчийн хэлснийг мэдэж авахын тулд Матай 13:10–12-ыг ангийн гишүүдээр уншуул.

- Аврагч үүнийг хэлэхдээ ямар утга санаа илэрхийлсэн гэж та нар боддог вэ?

Сүнслэг байдлын хувьд үүнийг ойлгоход бэлэн байдаг хүмүүст Их Эзэн үнэнийг илэрхийлдгийг тайлбарла. Итгэл хийгээд дуулгавартай байдлаар үнэнийг хүлээн авдаг хүмүүс улам илүүгээр үнэнийг цаашид хүлээн авсаар байдаг. Сүнслэг байдлын хувьд бэлтгэгдээгүй хүмүүс, түүнчлэн үнэнийг хүлээн авахад бүтэлгүйтсэн буюу зүрх сэтгэлдээ үүнийг эргэлзээтэй хүлээн авдаг хүмүүс өөрсөддөө байгаа үнэнийг аажмаар алдах болно.

Бэлэг тэмдгүүд бүхий түүхүүд нь сүнслэг талаараа бэлтгэгдсэн хүмүүс бэлэг тэмдгүүдийн утга учрыг ийм замаар ойлгож, үнэнийг илэрхийлдэг байна. Сүнслэг талаараа бэлтгэгдээгүй хүмүүс утга санааг нь ойлгодоггүй.

Аврагчийн үед байсан зарим хүмүүс түүний сургаалт үлгэрүүдийн утга санааг ойгодог байсан хэдий ч, олон хүн ойлгодоггүй байжээ. Өнөөдөр ч гэсэн мөн тийм байна. Сүмийн зөв шударга гишүүдийн дунд сүнслэг ойлголтын олон түвшин байдаг.

2 Нифай 28:30, Сургаал ба Гэрээ 42:49–50-ийг ангийн гишүүдээр уншуул.

- Бид Бурханаас үнэнийг хэрхэн сурдаг талаар эдгээр судрууд юу зааж байна вэ?

Сайн мэдээ, судрууд хийгээд нэн ялангуяа ариун сүмд ашиглагддаг бэлэг тэмдгүүдийн утга санааг бид ойлгож чадах түвшинд хүртэл сүнслэг талаараа хөгжих боломж бидний хүн бүгдэд бий гэдгийг тайлбарла.

“Бүх юмс адил төстэй зүйлүүдтэй байдаг ба бүх зүйлс, биет хийгээд сүнслэг зүйлс аль аль нь бүтээгдсэн бөгөөд миний тухай гэрчлэхээр хийгдсэн бөлгөө” (Мосе

Хамгийн Ариун Нандин Бэлэг Тэмдгийн Сургаалууд Ариун Сүмд Өгөгддөг

Хамгийн ариун нандин бэлэг тэмдгийн сургаалууд ариун сүмд өгөгддөг гэдгийг тайлбарла. Ариун сүмийн сургаалууд хийгээд ёс жаягууд нь бэлэг тэмдгийн хэлбэрээр биднийг мөнх амьдрал тийш хийх аянд хөтөлж, Бурханы оршихуйд бэлэг тэмдгээр орсноор төгсдөг билээ. Зурагласан дүрүүд, биет юмс, хувцас өмсгөх, тэмдгүүд өгөх түүнчлэн ариун сүмд хийгддэг бүх үйл явдлууд бэлэг тэмдгийн шинжтэй юм. Эдгээр бэлэг тэмдгүүд ойлгогдох үед

тэдгээр нь үнэнийг танин мэдэж, сүнслэг талаараа өсөхөд хүн болгонд туслах болно.

Зарим бэлэг тэмдгийн утга шууд ойлгогддог буюу гаднаас нь харахад ойлгомжтой байдаг. Ариун сүм өөрөө ч бэлэг тэмдэг юм:

“Хэрэв та ариун сүмүүдийн аль нэгийг шөнийн цагаар бүрэн гэрэлтүүлэгдсэн байхыг нь харвал, хичнээн сэтгэл татам дүр төрхтэйг мэдэх болно. Гэрэлд умбасан Их Эзэний өргөө түнэр харанхуйд сүндэрлэн, сүнсний харанхуй руу чиглэсэн дэлхийн гэрэлт цамхаг лугаа, Есүс Христийн сайн мэдээний хүч хийгээд сүнслэг онгодын бэлэг тэмдэг болон сүндэрлэх бөлгөө” (*Ариун Сүмд Ороход Бэлтгэх нь*, 10).

Ариун сүмийн хувцас бол мөн л бэлэг тэмдэг юм. Бид ариун сүмд ороод ердийн хувцсаа цэвэр ариуны бэлэг тэмдэг болсон ариун сүмийн цагаан хувцсаар сольдог. Ерөнхийлөгч Жэймс И. Фауст хэлэхдээ:

“Бурхан бол хүмүүсийг нүүр тал харагч биш’ [Үйлс 10:34] гэдэг зарчим нь ариун сүмийн шүтээний тулгуур зарчим мөн. Ариун сүмүүдийн ариусгагдсан ханануудын дунд албан тушаал, хөрөнгө чинээ, нийгмийн байдал, яс үндэс буюу боловсролын ялгаа байдаггүй. Бүгд адилхан цагаан хувцас өмсдөг. Бүгд адилхан заавар хүлээж авдаг. Бүгд нэгэн адил гэрээнүүд болон амлалтууд хийдэг. Хэрэв тэд өөрсдөд нь тавьдаг шаардлагуудын дагуу зохистой амьдрах юм бол бүгдээрээ адилхан мөнхийн адислалуудыг хүлээж авдаг. Бүтээгчийнхээ өмнө бүгдээрээ адил эрх тэгш билээ” гэжээ (in *Conference Report*, Apr. 1997, 23; or *Ensign*, May 1997, 20).

Ариун сүмийн ёслолуудыг хүлээн авч, Бурхантай гэрээ хийсэн гишүүд үлдсэн амьдралынхаа туршид тусгай гармент (дотуур өмсгөл) өмсдөгийг тайлбарла. Дараах мэдэгдлийг унш:

“Гармент нь ариун гэрээнүүдийг төлөөлдөг. Энэ нь даруу төлөв байдлыг хөхүүлэн дэмждэг бөгөөд өмсөгчийнхөө бамбай ба хамгаалалт болдог. . . . Бидний биеийг халхлагч энэхүү гармент нь эдгээр гэрээнүүдийн, нүдэнд харагдахуйц, бодит сануулагч болдог. Сүмийн олон гишүүний хувьд гармент нь түүнийг өмсөгч уруу таталттай учирсан үед хамгаалах халхавч болдог билээ. Энэ нь бусад зүйлсийн дотор Бурханы хуулиудад, түүний дотор ёс суртахууны жишигт гүнээ хүндэтгэлтэй хандахыг бэлэгдэн харуулдаг” (*Ариун Сүмд Ороход Бэлтгэх нь*, 20, 23).

Урьдчилан томилсон ангийн нэг гишүүнээс Ах нарын нэг нь ариун сүмийн гарментын зорилгын талаар хэрхэн дүрслэн тайлбарласныг нэгтгэн дүгнэхийг хүс (*Ариун Сүмд Ороход Бэлтгэх нь*, 20–21, 23).

Ариун сүмийн ёслолын бараг юм болгон нь бэлэг тэмдгийн шинжтэй байдаг гэдгийг тайлбарла. Энэ нь ариун сүмийн индаументийн бэлэг тэмдгийн мөн чанарыг сүнслэг мэдрэмжээр боломжийнхоо хэрээр мэдрэх бэлтгэлтэй байвал зохино гэсэн утгатай юм.

- Ариун сүмд сүнслэг мэдрэмжтэй байхаас нь хүнийг юу хөндийрүүлдэг вэ?

Ангийн гишүүд дараах зүйлүүдийг дурдаж болно:

1. Хүн зохистой биш байж болно. Чин сэтгэлээсээ наманчилдаггүй, ариун сүмд орохын төлөө даруу бөгөөд залбиралтайгаар бэлтгэдэггүй хүнд бэлэг тэмдгүүд нь амьгүй, тэдгээрийн утга санаа нь үл ойлгогдох болно.
 2. Хүнд итгэл дутагдаж болно. Есүс Христэд хийгээд ариун сүмийн ёслолд итгэдэггүй хүн ариун сүмийн индаументийг ойлгоход зайлшгүй шаардлагатай сүнслэг онгодыг Ариун Сүнснээс хүлээн авдаггүй.
 3. Хүн ёслолуудын гаднах байдалд анхаарлаа хэт төвлөрүүлснээс бэлэг тэмдгүүдээр төлөөлөгддөг хүч нөлөө ихтэй сургаалуудыг ажиглахгүй өнгөрөөж болно.
- Бид ариун сүмд сүнслэг мэдрэмжтэй байхын тулд хэрхэн бэлтгэж болох вэ?

Дүгнэлт

Ариун сүмд анх удаа явж байгаа хүмүүс олон шинэ зүйлийг мэдэж авдаг бөгөөд Их Эзэний Сүнсний хүчийг мэдэрдэг гэдгийг тайлбарла. Ариун сүмийн тухай мэдлэгтэй болохын төлөө өөрсдийгөө сүнслэг талаар бэлтгэхэд нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Танилцуулагдаж байгаа бүх зүйлийг нэг удаагийн явалтаар ойлгож чадахгүй гэдгийг тэдэнд сануул. Тэд ариун сүмд боломжийнхоо хэрээр аль болох олон удаа орсноор мэдэж сурах зүйлээ үргэлжлүүлэх бөгөөд сүнслэг мэдрэмжээ үргэлжлүүлэн шинэчилж чадна.

Хаалтын залбирал хийхийг хэн нэгнээс хүс.



АРИУН СҮМД ОРОХОД БЭЛТГЭХ НЬ

*“Миний хүмүүс
Их Эзэний нэр
дээр надад өргөө
барихын хэрээр,
мөн аливаа цэвэр
бус зүйлийг үүнд
оруулахгүй бай-
хын хэрээр энэ нь
бузарлагдахгүй
байж, миний
алдар суу үүн
дээр байх болно”
(С ба Г 97:15).*

ЗОРИЛГО

Ариун сүмд зохистойгоор ороход бэлтгэхэд ангийн гишүүдэд тусална.

ХИЧЭЭЛИЙГ ЗААХ НЬ

Нээлтийн залбирал хийхийг хэн нэгнээс хүс.

Ямар нэгэн асуулт байгаа эсэхийг нь ангийн гишүүдээс асуу. Их Эзэний Сүнсээр удирдуулан мөн бүх асуултуудад өөрийнхөө чадлаар хариулахад шаардлагатай цагийг зарцуул. Ариун сүмийн ажлын зарим зүйлүүдийг ариун сүмээс гадуур ярилцдаггүйг санагтун.

Хүн Бүр Ариун Сүмд Ороход Бэлтгэх Ёстой

Хүн бүр ариун сүмийн бүрэн адислалууд уруу хөтлөх алхмууд хийхийн тулд хувийн хариуцлага хүлээх ёстойг тайлбарла.

Дараах таван санааг товч ярилц. Эдгээр санаа тус бүр нь ариун сүмд ороход бидний бэлтгэх арга замыг харуулах болно. Та нар эдгээрийг ярилцахдаа санаа тус бүрийг самбар дээр жагсаан бичиж болно.

1. Хүн бүр зохистой байх ёстой.

Сургаал ба Гэрээ 97:15–17-г уншихыг ангийн гишүүдээс хүс.

- Ариун сүмд ороход зохистой байхын ач холбогдлын талаар энэ хэсэг та нарт юу заадаг вэ?

“Көртландын Гэгээнтнүүдийг ариун сүм барихаар бэлтгэж байхад нь Их Эзэн, Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан тэдэнд өгсөн зөвлөгөөндөө харьцаа хандлага хийгээд зөв шударга зан төрхийг онцолсныг” анхааралтай авч үзэхийг Ерөнхийлөгч Ховард В.Хантер биднээс хүсчээ.

Энэ зөвлөгөө Сургаал ба Гэрээ 88:119-т байдаг. Энэ хэсгийг уншихыг ангийн гишүүдээс хүс.

“Эдгээр харьцаа хандлага хийгээд зан төрх нь чухамдаа бидний хүн бүр юу хүсч, юуг эрэлхийлж буйн тусгал байдаг уу?” гэсэн Ерөнхийлөгч Хантерын асуултыг мөн анхааралтай авч үзэхийг

ангийн гишүүдээс хүс (“The Great Symbol of Our Membership,” *Ensign*, Oct. 1994, 2).

2. Хүн болгон даруу байх ёстой.

Хүн болгон дээрээс заагдах хүсэл эрмэлзэлтэйгээр даруу төлөв байдалд ариун сүмд орох ёстой.

- Бид ариун сүмд үйлчилж байхад буюу сурахад даруу байдал яагаад ийм их чухал байдаг вэ?

Сургаал ба Гэрээ 136:32–33-ыг ангийн гишүүдээр уншуул.

- Энэ хэсэг даруу төлөв байдлын ач холбогдлын талаар юу зааж байна вэ? Та нар ариун сүмд анх удаа орохдоо энэ зөвлөгөөг хэрхэн хэрэглэж болох вэ?

3. Ариун сүмийн ёслолууд хийгээд гэрээнүүдийг хүлээн авах нь мөнх амьдралыг олоход зайлшгүй чухал гэдгийг хүн бүр ойлгосон байх ёстой.

“Өөрсдийгөө зохион байгуул; хэрэгтэй юм болгоныг бэлтгэ; мөн орд өргөө байгуул, бүр залбирлын өргөө, мацгийн өргөө, итгэлийн өргөө, суралцахын өргөө, алдар суугийн өргөө, эмх журмын өргөө, Бурханы өргөөг байгуул” (С ба Г 88:119).

Ерөнхийлөгч Харолд Б.Ли хэлэхдээ: “Эдгээр хожмын өдрүүдэд мэргэн Тэнгэрлэг Эцэгээр бидний бүхий л амьдралын туршид удирдамж хийгээд хамгаалалт болон бидэнд илчлэгдсэн ариун сүмийн ёслолуудыг, Бурхан, Есүс Христ хоёрын амьдардаг сэлэстиэл хаант улс дахь өргөмжлөлийг хүртэхийн төлөө та, бид хүлээн авахгүй байх учиргүй” гэжээ (“Enter a Holy Temple,” *Improvement Era*, June 1967, 144).

Ерөнхийлөгч Жозеф Филдинг Смит хэлэхдээ: “Эдгээр адислалууд нь Их Эзэнээс бидэнд санал болгосон агуу их үнэт сувд, итгэлтэй байдлаар маань дамжин бидэнд ирдэг бөгөөд учир нь эдгээр нь энэ амьдралд бидний хүлээн авч чадах хамгийн агуу адислалууд юм. Энэ нь Сүмд ирдэг гайхамшигт зүйл боловч, та нар Их Эзэний өргөөнд гэрээнүүд хийж, өнөөдөр дэлхий дээр өөр ямар ч газарт өгөгдөж үл чадах тэрхүү түлхүүрүүд хийгээд эрх мэдлүүд өгөгдөхөөс нааш өргөмжлөлийг хүлээн авч чадахгүй” гэжээ (*Doctrines of Salvation*, comp. Bruce R. McConkie, 3 vols.[1954–56], 2:253).

4. Ариун сүмийн гарментыг өмсөхийн ач холбогдлыг хүн бүр ойлгодог байх ёстой.

Ариун сүмийн ёслолд оролцогчид ариун санваарын гарментыг өмсөх онцгой эрхтэй байдгийг тайлбарла. Тэргүүн Зөвлөл Сүмд хандаж хэлсэн үгэндээ:

“Ариун сүмд гарментаар хувцасласан Сүмийн гишүүд түүнийг бүх амьдралынхаа турш өмсөх гэрээ хийдэг. Энэ нь үүнийг өдөр, шөнийн аль ч цагт дотуур хувцас болгон өмсч байх ёстой гэсэн үг юм. . . .

“Үндсэн зарчим нь бол гарментыг байнга өмсч байх ёстой бөгөөд түүнийг тайлах шалтгийг эрж хайх ёсгүй. . . . Гарментыг зайлшгүй тайлах боллоо гэхэд . . . түүнийг аль болох түргэн буцааж өмсөх ёстой.

“Даруу төлөв байдлын зарчмууд хийгээд биеийг зохих байдлаар хааж байх нь гэрээний нэг хэсэг болж байгаа бөгөөд заавал өмсөх ёстой хувцасны төрөл юм. Индаумент хүртсэн Сүмийн гишүүд, Их Эзэнтэй хийсэн ариун нандин гэрээнүүдийг нь сануулагч, мөн уруу таталт хийгээд муу ёрын сүнсний эсрэг хамгаалалт болох гарментыг өмсдөг. Гарментыг хэрхэн өмсөх нь Аврагчийг дагах дотоод сэтгэлийн шийдвэр төгс байдлын гадаад илэрхийлэл мөн” гэжээ (First Presidency Letter, to Oct. 1988).

5. Хүн болгон хувиараа хийгээд ариун нандин шүтээний хувьд бэлтгэгдсэн байх ёстой.

Ариун сүмд, ёслолуудын үеэр, түүнчлэн өмнө болон дараа нь, бясалган бодох хийгээд Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христэд улам ойр байх аятай боломжууд хувь хүнд олддог. Хариулах ёстой асуулт, хөнгөлөх ёстой ачаа, шийдвэрлэх ёстой асуудлууд хүн болгонд тохиолддог. Олон хүмүүс ариун сүмийг дэлхийгээс холдож, Тэнгэрлэг Эцэгтэй харилцах газар хэмээн үнэлдэг. Олон хүмүүс ариун сүмд асуултуудынхаа хариу, амар амгалан хийгээд баяр баясгаланг олдог.

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон хэлэхдээ: “Ариун сүмүүд бол хувийн илчлэлт хүлээн авдаг газар юм. Би асуудлууд, бэрхшээлүүдэд дарагдсан үедээ Их Эзэний Өргөө рүү зүрх сэтгэлдээ залбиралтайгаар хариулт эрэн очдог байсан. Эдгээрийн хариултууд тодорхой мөн алдаа мадаггүйгээр ирдэг байсан” гэсэн (“What I Hope You Will Teach Your Children about the Temple,” *Ensign*, Aug. 1985, 8).

Ямар нэг онцгой хэрэгцээ шаардлагатай байгаа хүмүүсийн нэрсийг бид ариун сүмд өгч болох бөгөөд ингэснээр ариун сүмд орж байгаа хүмүүс тэдгээр хүмүүсийн нэрийн өмнөөс итгэлээрээ залбирлуудаараа нэгдэж чадна.

Ариун Сүмд Анх Удаа Орохдоо Тусгайлан Бэлтгэх нь

Дараах мэдээлэл нь ариун сүмд анх удаа явахад зайлшгүй шаардлагатай бүх бэлтгэлийг хангахад хүн болгонд туслах бөгөөд энэ явалт нь хүмүүсийн сэтгэл санааг өргөдөг гэдэгт бат итгэлтэй бай. Ангийн гишүүдийн нөхцөл байдалтай тохирох мэдээллийг тэдэнтэй ярилц.

1. *Ариун Сүмийн Зөвшөөрлийн Бичиг*. Ариун сүмийн зөвшөөрлийн бичигтэй бай. Зөвхөн хүчин төгөлдөр зөвшөөрлийн бичигтэй хүмүүс л орж болох учраас ариун сүмд очихдоо ариун сүмийн

зөвшөөрлийн бичгээ авч оч. Та нар зохистой амьдарсан тохиолдолд, дараагийн хоёр жил нь уг зөвшөөрлийн бичгээр Сүмийн аль ч ариун сүмд өөрийнхөө хүссэнээр хичнээн ч удаа орж болно. Ариун сүмийн зөвшөөрлийн бичгээ шинэчлэхийн тулд та нар бишопын зөвлөлийн гишүүн буюу салбарын ерөнхийлөгчтэйгөө мөн гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн буюу номлолын ерөнхийлөгчтэйгөө ярилцлагад орох ёстой.

2. *Ариун Сүмд Орох Аяллыг Төлөвлөж, Цаг Товлох нь.* Та нар индаумент буюу лацдан холбох ёслол хүлээж авахаар ариун сүмд явахынхаа өмнө цаг товлохоор ариун сүм рүү утасд. Ариун сүм дээр хэзээ ирж, ямар хугацаагаар тэнд байхыг мөн юу авж ирэх ёстойгоо лавлаж мэд. Шаардлагатай бол орчуулгын тусламж хүс.
3. *Аялын Төлөвлөгөө.* Хэрэв та нар ариун сүмээс алс хол амьдардаг бол, дараах зүйлүүдийг анхаарах хэрэгтэй:
 - Унаа, орон байр, хоолны асуудлыг урьдчилан зохицуул. Хэрэв боломжтой бол хэсэг бүлгээрээ хамт аялах нь та нарт давуу талтай байж болно.
 - Хэрэв шаардлагатай бол, ариун сүм байрладаг орны мөнгөн тэмдэгтээр мөнгөө урьдчилан солиулах арга хэмжээ ав.
 - Бүх зардалд хүрэлцэхүйц мөнгөтэй бай. Нэмж гармент худалдаж авах, ариун сүмийн хувцас түрээсээр авч хэрэглэх, түүнчлэн орон байр, унааны зардал төлөх шаардлага гарч болно. (Олон ариун сүмүүдэд хувцас түрээсэлж авах боломжгүй байдаг гэдгийг анхаар. Тэргүүн Зөвлөлийнхөн бүр гишүүдийг ариун сүмийн хувцсыг өөрсөддөө худалдаж авахын уриалдаг.)
4. *Хувцас.* Ням гарагийн цуглаануудад хувцасладаг шигээ хувцаслахаар төлөвлө. Эмэгтэйчүүд ариун сүмд өмдтэй орох ёсгүй.
5. *Дагалдагч.* Ариун сүмд анх удаа явж байгаа бүх хүмүүс дагалдагчид буюу хамт явагчидтай байж болно. Энэ нь урьд нь ариун сүмд орсон адил хүйсийн садан төрөл буюу найз чинь байж болно, эсвэл ариун сүмийн ажилтнуудын нэг нь тусалж болно. Ариун сүмийн ажилтнууд хэдийд ч нөхөрсгөөр газарчлахад бэлэн байх болно.
6. *Холболтын Ажил.* Хэрэв та нар нас барсан өвөг дээдсийнхээ төлөө холболт хийлгэхээр төлөвлөж байгаа бол, бөглөж бэлэн болгосон гэр бүлийн гишүүдийн бүртгэлийг авч очих хэрэгтэй. Хэрэв та болон таны эхнэр буюу нөхөр холболт хийлгэж байгаа бол эсвэл хүүхдүүдээ өөрсөдтэйгөө холбуулах гэж байгаа бол гэр бүлийнхээ бичээсийг авчирсан байх ёстой. Хэрэв та гэрлэх гэж байгаа бол орон нутгийнхаа иргэний бүхий л хуулийг биелүүлж, гэрлэлтийнхээ хүчин төгөлдөр гэрчилгээг авчирах хэрэгтэй. Амьд байгаа хүмүүс хийгээд нас барагсдын төлөө ариун

сүмийн ёслолуудыг хэрхэн хийлгэх талаар нарийвчилсан мэдээллийг *Member's Guide to Temple and Family History Work* (34697)-аас анхааралтай уншина уу. Та мөн очихоор төлөвлөж байгаа ариун сүмийнхээ бичээс хөтлөгчтэй холбоо барьж болно.

7. *Хүүхдүүдийг Анхаарч Халамжлах*. Хэрэв холболтын ёслолд оролцохоор хүүхдүүд ариун сүмд явж байгаа бол, ариун сүм дотор байдаг өсвөр үеийнхний төв тэднийг холболтын өрөөнд та нартай нийлэх хүртэл анхаарал халамж тавина. Ёслолд оролцоход нь зориулж, хүүхдүүдэд цагаан хувцас өгдөг. Холболтын ёслол дууссаны дараа хүүхдүүд та нарыг өсвөр үеийнхний төвд буцаж очиж хүлээнэ. Холболтын ёслолд оролцохгүй хүүхдүүдийг харж хандах асуудлыг ариун сүм хариуцахгүй.
8. *Ариун Сүмийн Гармент*. Та нар ариун сүмд орохоосоо өмнө ариун сүмийн гарментаас нэг буюу хоёр хосыг худалдаж авах хэрэгтэй. Ариун сүмд орохоосоо өмнө гарментыг бүү өмс. Өөрийнхөө индаументийг хүлээн авч, өөрийн хэмжээ болон хүссэн даавуун материалыг сонгож авсны дараа та нар нэмэлт гарментууд худалдан авч болно. Зарим хүмүүс өөр гарментууд худалдаж авахынхаа өмнө анхны гарментуудыг угааж, яг тохирох хэмжээг нь тогтоох дуртай байдаг. Ариун сүмийн гарментуудыг Сүм үйлдвэрлэдэг бөгөөд Сүмийн Хангамжийн Үйлчлэлүүдээр дамжуулан худалдан авч болно.
9. *Ариун Сүмийн Хувцас*. Гишүүд өөрсөддөө ариун сүмийн хувцас худалдаж аван хэрэглэдэг байхыг Тэргүүн Зөвлөл урамшуулан дэмждэг билээ. Зарим ариун сүмд ариун сүмийн хувцсыг бага үнээр түрээсэлж болох хэдий ч, гишүүд өөрийн ариун сүмийн хувцастай болж түүнийгээ хэрэглэдэг байх нь зүйтэй юм. Бишоп буюу салбарын ерөнхийлөгч нь энэ хувцсыг хаанаас худалдан авч болох тухай мэдээллийг өгч чадна.

Эгч нар өөрсдийнхөө хуримын даашинзыг ариун сүмийн хуриманд өмсч болно, гэхдээ даашинз нь цагаан, урт ханцуйтай, энгийн даруу материал болон хийцтэй, зориуд гаргасан хээ угалзгүй байх ёстой.

*“Ариун сүмийн -
ёслолуудыг мэргэн
Тэнгэрлэг Эцэг
зохиосон юм . . .
та бид хоёр сэлэс-
тиэл хаант улс-
дахь өргөмжлө-
лийг хүртэхгүй
байх ёсгүй”
(Ерөнхийлөгч
Харолд Б.Ли).*

Дүгнэлт

Ариун сүмийн ажлын ариун нандин байдлын талаарх гэрчлэлээ хуваалц. Ангийн гишүүд ариун сүмд орохоор бэлтгэж байгаад баяртай байгаагаа илэрхийл.

Хаалтын залбирал хийхийг хэн нэгнээс хүс.

Энэ хичээлийн дараа ангийн оролцогчид болон багш нар боломжтой газарт ариун сүмд хамтдаа орох хэрэгтэй.



АРИУН СҮМД ОРШНООР ИРЭХ АДИСЛАЛУУДЫГ ЦААШИД ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ХҮРТЭХ НЬ

*“Учрыг болгоог-
тун, энэ өргөөг би
хүлээн авлаа, мөн
миний нэр энд
байх болно; мөн
энэ өргөөнд миний
бие өөрийнхөө хү-
мүүст өөрийгөө
энэрэлд тунхаглах
болно” (С ба Г
110: 7).*

ЗОРИЛГО

Ариун сүмд хийх анхны аяллыг эргэн санахад мөн бүх амьдралынхаа туршид ариун сүмийн баяр баяслыг эдлэхэд бэлтгэхэд ангийн гишүүдэд тусална.

БЭЛТГЭЛ

1. Энэ хичээлийг сэтгэгдлээ хуваалцах цаг болгоход бэлтгэ. Ангийн ихэнх гишүүд ариун сүмд анх удаа орсон тухайгаа ярилцах хүсэлтэй байх болно.
2. Сургаал ба Гэрээ 110:1–10-ыг уншиж, энэ тухай өөрийн сэтгэгдлээ хуваалцахаар бэлтгэхийг ангийн нэг гишүүнд урьдаас даалга.
3. *Ариун Сүмд Ороход Бэлтгэх нь*-ийн 23–24-р хуудсан дахь Елиагийн тухай мэдээллийг нэгтгэн дүгнэж ярихыг ангийн нэг гишүүнд даалга.
4. Ариун сүм рүү явах анхны аяллын үед гарч ирсэн асуултуудад хариулахаар бэлтгэ, гэхдээ ариун сүмд орсон үед тодорхой болох асуултууд хийгээд мэдээллийн тухай ярилцах шаардлагагүй. Ийм асуултууд гарсан үед хувь хүмүүсийг ариун сүмд орох нэмэлт аяллыг төлөвлөхийг уриал.

ХИЧЭЭЛИЙГ ЗААХ НЬ

Нээлтийн залбирал хийхийг хэн нэгнээс хүс.

Ямар нэгэн асуулт байгаа эсэхийг нь ангийн гишүүдээс асуу. Их Эзэний Сүнсээр удирдуулан мөн асуултуудад өөрийнхөө чадлаар хариулахад шаардлагатай цагийг зарцуул. Ариун сүмийн ажлын зарим зүйлүүдийг ариун сүмээс гадуур ярилцдаггүйг санагтун.

Ариун Сүмийн Үйлчлэлийг Хайрладаг Байх нь

- Ариун сүмд байхад та нарт ямар сэтгэгдэл төрсөн бэ?

Ариун сүмийн үйлчлэл нь ариун сүмд байн байн ордог хүмүүсийн амьдралд байнгын адислалуудыг авчирсаар байх болно гэдгийг тайлбарла. Ариун сүмд орсон явдал нь тэдний оюун санаанд сэргэг шинэхэн байгаа үед аяллынхаа тухай бодол санаагаа бичиж болно гэдгийг ангийн гишүүдэд тайлбарла. Тэд сэтгэгдлээ

бичиж болох хэдий ч ариун сүмээс гадуур ярилцаж үл болох ариун сүмийн ажлын талаар зарим тодорхой зүйлүүдийг бичих ёсгүй гэдгийг сануул.

- Ариун сүмийн үйлчлэлийг насан туршдаа хайрлаж явахын тулд та нар юу хийж болох вэ?

Ангийн гишүүдийн санаануудыг самбар дээр бич. Түүнчлэн та дараах санаануудыг танилцуулж болно:

1. Ариун сүмд орсон явдлаа өдөр болгон тунгаан бод.

Зарим хүмүүс бусдыгаа бодвол ариун сүмд орох илүү их боломжтой байдгийг тайлбарла. Гэвч бид ариун сүмд нэгэнтээ орж, тэнд Сүнсийг мэдэрсэн бол ариун сүмийн ёслолуудын болон тэнд хийсэн гэрээнүүдийнхээ талаар өдөр болгон тунгаан бодож байх ёстой. Ингэх нь илүү зөв шударга байдлаар бодох хийгээд ажиллахад биднийг өдөр бүр урамшуулан дэмжих болно.

Ариун сүмийн тухай ном болгоныг бид эргэн санаж чадахгүй хэдий ч, ариун сүмийн аялал бүрийнхээ дараа аль болох их зүйлийг эргэн санахыг хичээх хэрэгтэй. Мөн түүнчлэн бид судрууд болон ариун сүмийн талаар бошиглогчдын хэлсэн үгнүүдийг уншиж судлах ёстой. Эдгээрийн заримыг энэ курс хичээлд танилцуулсан билээ.

Ариун Сүмд Ороход Бэлтгэх нь товхимолын 10-р хуудсан дахь дараах мэдэгдлийг ангийн нэг гишүүнээр нэгтгэн дүгнүүлж болно:

“Ариун сүмийн ёслолыг анх ороод л бүрэн ойлгохгүй байж болно. Зөвхөн заримыг нь л ойлгох болно. Дахин дахин эргэн очигтун. Сурахаар эргэн очигтун. Ухаж ойлгоход нэн төвөгтэй буюу хүнд хэцүү зүйлүүд мөн толгой эргүүлмээр буюу учир битүүлэг зүйлүүд нь танд танигдах болно. . . .

“Ариун сүмд индаумент хүртэх хэсэгт оролцох эсвэл холболтын гэрч болох завшаан тохиосон үед та өөрийн тань үзсэн зүйл таны өмнө юуг илтгэн харуулсны гүн гүнзгий утга учрыг тунгаан бодогтун. Ариун сүмд орсны дараах өдрүүдэд эдгээр зүйлсийн талаар эрэгцүүлэн бодогтун; нам гүм хийгээд залбиралтайгаар тэдгээрийг дахин цэгнэж үзвэл, мэдлэг тань өргөжин тэлэхийг та олж мэднэ.

“Ариун сүмд орох явдлын агуу их нэг үнэ цэнэ бол энэ дэлхийд холбогдох Бурханы зорилгуудын бүхнийг хамарсан, өргөн цар хүрээг төлөөлдөг явдал мөн. Бид ариун сүмд орсноороо (энд эргэн ирж, ой санамжаа дахин сэргээж болно) амьдралын үйл явдлууд нийт дүр төрхөөрөө илрэн харагддаг. Бид хаана байгаага мөн бид хэзээ замаасаа тэр дорхноо гажиж болохыг тодоор харж чадна”

2. Ариун сүмийн шүтээний бүх гол цөм нь Аврагч Есүс Христ гэдгийг санагтун.

Ариун сүмүүд барихын нэгэн чухал учир шалтгааны тухай судрууд “Хүний Хүү өөрийнхөө хүмүүст өөрийгөө тунхаглах газартай байж болохын тул” хэмээн заасан байдаг (С ба Г 109:5). Ариун сүмийн бэлэг тэмдгүүд хийгээд ёс жаягууд нь Аврагч дээр анхаарлаа төвлөрүүлэхэд бидэнд тусалдаг.

Аврагч өөрийгөө Көртландын ариун сүмд тунхагласан гэдгийг тайлбарла. Тэрээр өөрийнхөө өргөөг ариун сүм болгон хүлээж авахаар Иосеф Смит, Оливер Каудри хоёр дээр хүрч ирсэн билээ. Энэхүү айлчлалыг Сургаал ба Гэрээ 110:1–10-т тэмдэглэсэн байдаг. Судрын энэ хэсгийг уншиж, тайлбарлахыг урьдчилан томилсон ангийн нэг гишүүнээс хүс.

- Ариун сүмүүдийг барьж, тэдгээрт ордог хүмүүст Аврагч ямар адислалуудыг амласан бэ?

Ариун Сүмд Гэр Бүлүүд Мөнхөд Холбогддог

Малахи 4:5–6-г уншихыг ангийн гишүүдээс хүс.

Ариун Сүмд Ороход Бэлтгэх нь товхимолын 23–24-р хуудсан дахь Елиагийн тухай мэдээллийг дүгнэж ярихыг урьдчилан даалгасан ангийн нэг гишүүнээс хүс.

Елиа эргэн ирж, гэр бүлүүд мөнхөд оршихын тулд ариун сүмүүдэд хамтдаа холбогдох боломжийг олгодог санваарын түлхүүрүүдийг сэргээж өгснийг тайлбарла.

Сургаал ба Гэрээ 110:13–16-г ангийн гишүүдээр нэгтгэн дүгнүүл. Тэгээд *Ариун Сүмд Ороход Бэлтгэх нь* товхимолын 28-р хуудсан дахь дараах мэдэгдлийг уншихыг ангийн нэг гишүүнээс хүс:

“1836 оны 4 сарын 3-ны тэр л өдрөөс эхлэн хүүхдүүдийнх нь зүрх сэтгэл эцгүүд рүүгээ эргэж эхэлсэн юм. Энэ үеэс хойш ёслолууд нь цаг зуурын биш, харин байнгын болсон билээ. Холболтын хүч бидэнтэй хамт байлаа. Үнэ цэнээрээ холболтын хүчнээс давж гарах өөр эрх мэдэл гэж үгүй билээ. Энэхүү хүч нь амьд байгаа хүмүүс болон нас барагсдын аль алиных нь төлөө зохих эрх мэдэлтэйгээр гүйцэтгэгддэг бүх ёслолуудыг утга учиртай, мөнхийн хувиршгүй чанартай болгодог билээ”

Матай 16:19-д тэмдэглэсэнчлэн, Аврагч Өөрийн Төлөөлөгч Петртэй ярихдаа, Тэрээр холболтын хүчийг тодорхойлон дүрсэлжээ. Энэ шүлгийг ангийн гишүүдээр уншуул.

Чухамхүү эдгээр түлхүүрүүдийг өнөөдөр Сүмийн Ерөнхийлөгч бөгөөд бошиглогч атгаж байдгийг тайлбарла. “Энэхүү холболтын ариун нандин хүч нь эдүгээ Сүмд байна. Энэхүү эрх мэдлийн ач холбогдлыг мэддэг хүмүүсийн ариун нандин бясалгалаас илүү эрхэм зүйл гэж үгүй бөлгөө. Үүнээс илүү нягт холбоотой зүйл юу ч

үгүй билээ. Дэлхий дээр холболтын энэ хүчийг атгагч харьцангуй цөөн тооны хүмүүс аль ч цаг үед байдаг бөгөөд холболтын хүчийг хүртсэн ах нар ариун сүм болгонд байдаг билээ. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн ерөнхийлөгч, бошиглогч, үзмэрч болон илчлэгчээс буюу үүнийг бусдад өгөхөөр түүний томилогдогсдоос өөр хэнээс ч энэ хүчийг хүлээн авч чадахгүй” (Ариун Сүмд Ороход Бэлтгэх нь, 24, 26).

Холболтын ёслолууд нь эхнэр, нөхөр хоёрыг өөр хооронд нь болон эцэг эхчүүдийг хүүхдүүдтэй нь лацдан холбох холболтыг багтаадаг. Эцэг эхчүүд ариун сүмд холбогдсон бол тэднээс төрсөн хүүхдүүд нь эцэг эхийнхээ холболтын гэрээнд төрсөн учраас тэднийг эцэг эхтэй нь холбох шаардлагагүй байдаг.

- Ариун сүмд хамтдаа холбогдох нь тухайн гэр бүлийн бодол санаа, үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлнө гэж та нар боддог вэ?
- Ариун сүмийн холболт хийлгэснээр тухайн гэр бүлд ямар адислалууд ирнэ гэж та нар боддог вэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлэхдээ: “Өөрсдийнх нь хэлхээ холбоо булшнаас цааш үргэлжлэхийн төлөө залбирдаггүй эмэгтэй хүнийг жинхэнэ ёсоор хайрладаг эр хүн эсвэл эрэгтэй хүнийг жинхэнэ ёсоор хайрладаг эмэгтэй хүн ер нь байсан уу? Эцэг эх нь хайрт үрээ ирэх дэлхийд дахин тэднийх байгаасай гэж найдалгүйгээр ер нь оршуулдаг болов уу? Мөнхийн амьдралд итгэдэг хэн ч гэсэн тэнгэрийн Бурхан амьдралынх нь хамгийн эрхэм үнэт зүйл болох хөвгүүд, охидод нь гэр бүлийн харьцааны хамгийн утга төгөлдөр илэрхийлэл болсон хайрыг өгнө гэдэгт эргэлзэж чадна гэж үү? Үгүй ээ, үхлийн дараа ч гэр бүлийн холбоо үргэлжилж болно гэдгийг энэхүү учир шалтгаан шаарддаг. Хүмүүний зүрх сэтгэл үүнийг эгээрэн хүсдэг бөгөөд тэнгэрийн Бурхан үүний байх арга замыг илчилсэн билээ. Их Эзэний өргөөний ариун нандин ёслолууд үүнийг хангаж өгдөг” (*“Why These Temples?” Temples of The Church of Jesus Christ of Latter Day Saints* [1988], p.4).

НАС БАРАГСДАД ҮЙЛЧЛЭХ БОЛОМЖИЙГ АРИУН СҮМҮҮД БИДЭНД ОЛГОДОГ

Обадиа 1:21-ийг ангийн гишүүдээр уншуул.

Сүмийн гишүүд хэрхэн Сион Уулан дээр аврагчид болж чадах тухай Бошиглогч Иосеф Смит тайлбарлахдаа:

“Гэвч [Гэгээнтнүүд] Сион уулан дээр хэрхэн аврагчид болох ёстой вэ? Өөрсдийн ариун сүмүүдийг байгуулснаар, өөрсдийн баптисмын сангуудыг барьснаар, түүнчлэн бүх ёслолууд, баптисм, гишүүний баталгаа, угаалга, тосолгооны ёслолууд, томилолтууд хийгээд холболтын хүчийг нас барсан өвөг дээдсийнхээ нэрээр

“Манай ариун сүмүүдэд бусдын өмнөөс гүйцэтгэдэг энэхүү ажил нь Эзэний амьдралыг тодорхойлон харуулсан амин хувиа үл хичээн бүхнээ зориулах мөн золиослохтой адил сэтгэлээр хийгдэж байх ёстой”
(Ерөнхийлөгч Томас С.Монсон).

өөрсөд дээрээ эрхэмлэн хүлээж авснаар, түүнчлэн тэд анхны амиуулалтаар босч ирж, мөн өөрсөдтэйгөө хамт алдар суугийн хаан ширээнээ өргөмжлөгдсөн байхын тулд тэднийг гэтэлгэх болой, мөн эцгүүдийн зүрх сэтгэлийг хүүхдүүдтэй нь, хүүхдүүдийг эцгүүдтэй нь холбож өгөх гинжин хэлхээ энд байгаа нь Елиагийн зорилгыг хэрэгжүүлэх бөлгөө” гэжээ (*History of the Church*, 6:184).

Тэнгэрлэг Эцэг маань сайн мэдээний аврагч ёслолуудыг хүлээн авалгүй нас барсан хүмүүст зориулж эдгээр ёслолуудыг хүлээн авах арга замыг бэлтгэн өөрийн авралын төлөвлөгөөний нэг хэсэг болгосон гэдгийг тайлбарла. Сүнсний дэлхий дэх хүмүүс сайн мэдээг сонсох боломжтой байдаг. Тэд сайн мэдээг тэнд хүлээн авч болох хэдий ч, үүний ёслолуудыг өөрсдийнхөө төлөө хүлээн авч чадахгүй. Тэдний төлөө эдгээр ёслолуудыг ариун сүмүүдэд гүйцэтгэхийг Их Эзэн бидэнд зарлигласан юм. Бид гэр бүлийн түүхийн ажлыг хийхдээ онцгой чармайлт гаргах ёстой бөгөөд ингэснээр бид өвөг дээдсийнхээ төлөө ёслолуудыг хүртэж чадна.

Нас барагсдын төлөө ариун сүмүүдэд хийдэг ёслолууд нь баптисм, гишүүний баталгаа, санваарын томилолтууд, индаументүүд, түүнчлэн эхнэр нөхөр хоёрыг хооронд нь болон эцэг эхчүүдийг хүүхдүүдтэй нь холбох холболтуудыг багтаадаг.

Нас барагсдын төлөөх ёслолуудыг гүйцэтгэснээр бид тэдний төлөө үйлчлэхийн тулд нөхцөл байдлынхаа боломжоор ариун сүмд аль болохоор олон удаа эргэж очиж байх ёстой. Бид үйлчилж байгаа хүмүүсийнхээ амьдралыг адислахын хамт мөн өөрсдийнхөө амьдралыг ч адислах болно. Гэр бүлийн түүхийн ажлыг хэрхэн хийх мөн өвөг дээдсийнхээ төлөө ёслолуудыг хэрхэн гүйцэтгэх талаарх мэдээлэл *A Member's Guide to Temple and Family History Work* (34697)-д бий.

Ерөнхийлөгч Томас С.Монсон хэлэхдээ:

“Ариун сүмийн индаумент болон холболтын ёслолуудыг эрхэмлэн хүртэх нь бидний гэр бүлийн гишүүдийг улам ойртуулан нягтруулж, мөн талийгаач болсон бидний хайрт хүмүүст өөрсдийнхөө адил адислалуудыг авчрах гэр бүлийн гишүүн бүрийн хүсэл эрмэлзлийг хүчтэй болгох болно. . . .

“Манай ариун сүмүүдэд гүйцэтгэгддэг бусдын өмнөөс хийх энэхүү ажил нь мөн л өөрийгөө сэтгэл харамгүй зориулах хийгээд Эзэний амьдралыг тодорхойлогч золиослолын тэрхүү сүнсэнд хэрэгжих учиртай. Бид түүнийг дурсан санах үед, энэхүү амин чухал ач холбогдол бүхий ажилд өөрсдийнхөө хувь нэмрийг оруулахад илүү хялбар дөхөм болно. Эдгээр ариун өргөөдийн аль нэгийг бид харах бүрдээ зөвхөн өөрсдийнхөө төлөө төдийгүй, бас бидний нас барагсдын төлөөх мөнхийн боломжуудыг дотоод сэтгэлдээ эргэн санадаг” гэжээ (*Pathways to Perfection* [1973], 206– 7).

Дүгнэлт

Ариун сүмд орох нь бусдад үйлчлэх болон агуу их сүнслэг мэдлэгийг үргэлжлүүлэн олж авах боломжийг бидэнд олгодог гэдгийг онцлон тэмдэглэ. Дараах мэдэгдлийг хуваалц:

“Ариун сүмийн ажил ба үүнд түлхэц өгөгч удмын судалгаанаас илүү энэ Сүмд хамгаалалт болох ажил үгүй билээ. Сүнслэг байдлыг сайжруулагч үүнээс өөр ажил гэж үгүй билээ. Бидэнд илүү хүчийг өгөгч өөр ажил гэж үгүй билээ. Зөв шударга ёсны илүү өндөр жишгийг шаардагч өөр ажил гэж үгүй билээ. . . .

“Хэрэв бид ариун сүмийн ёслолын ажлын талаар илчлэлт хүлээн авбал, хэрэв бид аливаа шалтаг, өөрийгөө зөвтгөх явдалгүйгээр гэрээнд орвол Их Эзэн биднийг хамгаалах болно. Мөн амьдралын бэрхшээлүүддээ хангалттай сүнслэг онгодыг хүлээн авах болно. . . .

“Тиймээс ариун сүмд очигтун, очоод адислалуудаа хүртэгтүн. Энэ бол ариун нандин ажил юм” (*Ариун Сүмд Ороход Бэлтгэх нь*, 37).

Гэрчлэлээ хуваалцсанаар хичээлээ төгсгө. Их Эзэний Сүнсээр заалгахын тулд ариун сүм рүү олонтаа эргэн очиж байхыг ангийн гишүүддээ уриал.

Та *Mountain of the Lord* (53300) видео танилцуулгыг Сүмийн хангамжийн төвүүдээс олж авч гэртээ үзэж болно гэдгийг ангийн гишүүдэд сануулж болно. 73 минут үргэлжилдэг энэ видео танилцуулгад Солт Лэйкийн Ариун Сүмийг барьсан тухай түүхийг өгүүлдэг.

Хаалтын залбирал хийхийг хэн нэгнээс хүс.

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СУМ

MONGOLIAN



4 02368 54363 0

36854 363